

Жилийн үйл ажиллагааны тайлагнал /маягт 1/	
Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд Үнэт цаас гаргагчийн нийтлэг үүргийг хуульчилсан бөгөөд үнэт цаас гаргагч нь жилийн үйл ажиллагааны тайлан дараах маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллагад мэдээлэл ирүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэл хүргэх үүрэгтэй.	
Тайлагнах хугацаа	2023 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдөр
Үнэт цаас гаргагчийн нэр, улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, үнэт цаасны код, утасны дугаар	“МИК Холдинг” ХК, 9010001134, MSE:MIK, 11-328267
Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр	Монголын Хөрөнгийн Бирж
Бизнесийн үйл ажиллагааны салбар	Санхүүгийн бусад үйл ажиллагаа
Жилийн эцсийн санхүүгийн тайланд аудитын дүгнэлт гаргасан СЗХ-нд бүртгэлтэй аудитын компанийн нэр, бүртгүүлсэн огноо	
Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт хувьцааны тоо ширхэг	20,709,320
Жилийн тайланг бэлтгэсэн мэргэжилтэн, хянасан албан тушаалтны нэр	Хянасан: Гүйцэтгэх захирал Б.Гантулга
1.	Тайлант жилийн санхүүгийн тайлан /хураангуй тайлангийн үзүүлэлтийг бөглөж, санхүүгийн тайланг хавсаргана/
	Санхүүгийн байдлын үзүүлэлт Тайланг хавсаргав
	Орлогын тайлан Тайланг хавсаргав
	Өмчийн өөрчлөлтийн тайлан Тайланг хавсаргав
	Мөнгөн гүйлгээний тайлан Тайланг хавсаргав
1.1.	Жилийн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлт
	Хавсаргав

1.2.	Аудитын тодорхойлох захидал /тодорхойлох захидлыг энэхүү зааварт дурдсан агуулгын хүрээнд боловсруулсан байх/																											
	Байхгүй																											
2.	Үнэт цаас гаргагч нь тайлант хугацаанд санхүүгийн нөхцөл байдал, үйл ажиллагааны үр дүнд нөлөөлсөн хүчин зүйлс, удирдлагаас өгсөн үнэлгээ, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар товч тайлбарласан тайлан, мэдээлэл																											
2.1.	Үйл ажиллагааны үр дүн /санхүүгийн харьцааны үзүүлэлтүүд/	<table border="1"> <tr> <td colspan="2">Санхүүгийн үзүүлэлтүүд</td> </tr> <tr> <td colspan="2">Ашигт ажиллагаа</td> </tr> <tr> <td>Цэвэр хүүний маржин (NIM) *</td> <td>0.22%</td> </tr> <tr> <td>Нийт хөрөнгийн өгөөж (ROA) *</td> <td>2.49%</td> </tr> <tr> <td>Өөрийн хөрөнгийн өгөөж (ROE) *</td> <td>2.55%</td> </tr> <tr> <td colspan="2">Өөрчлөлтийн хувь (оны эхнээс)</td> </tr> <tr> <td>Нийт активын өөрчлөлт</td> <td>-0.44%</td> </tr> <tr> <td>Зээлийн багцын өөрчлөлт</td> <td></td> </tr> <tr> <td colspan="2">Хөрөнгөнд эзлэх хувь</td> </tr> <tr> <td>Өөрийн хөрөнгө/Нийт хөрөнгө</td> <td>99.41%</td> </tr> <tr> <td>Өр төлбөр/Нийт хөрөнгө</td> <td>0.59%</td> </tr> <tr> <td>Хөрвөх чадварын харьцаа</td> <td>0.22%</td> </tr> <tr> <td>Хөрвөх чадвартай хөрөнгө / Татан төвлөрүүлсэн хөрөнгө</td> <td>211.87%</td> </tr> </table>	Санхүүгийн үзүүлэлтүүд		Ашигт ажиллагаа		Цэвэр хүүний маржин (NIM) *	0.22%	Нийт хөрөнгийн өгөөж (ROA) *	2.49%	Өөрийн хөрөнгийн өгөөж (ROE) *	2.55%	Өөрчлөлтийн хувь (оны эхнээс)		Нийт активын өөрчлөлт	-0.44%	Зээлийн багцын өөрчлөлт		Хөрөнгөнд эзлэх хувь		Өөрийн хөрөнгө/Нийт хөрөнгө	99.41%	Өр төлбөр/Нийт хөрөнгө	0.59%	Хөрвөх чадварын харьцаа	0.22%	Хөрвөх чадвартай хөрөнгө / Татан төвлөрүүлсэн хөрөнгө	211.87%
Санхүүгийн үзүүлэлтүүд																												
Ашигт ажиллагаа																												
Цэвэр хүүний маржин (NIM) *	0.22%																											
Нийт хөрөнгийн өгөөж (ROA) *	2.49%																											
Өөрийн хөрөнгийн өгөөж (ROE) *	2.55%																											
Өөрчлөлтийн хувь (оны эхнээс)																												
Нийт активын өөрчлөлт	-0.44%																											
Зээлийн багцын өөрчлөлт																												
Хөрөнгөнд эзлэх хувь																												
Өөрийн хөрөнгө/Нийт хөрөнгө	99.41%																											
Өр төлбөр/Нийт хөрөнгө	0.59%																											
Хөрвөх чадварын харьцаа	0.22%																											
Хөрвөх чадвартай хөрөнгө / Татан төвлөрүүлсэн хөрөнгө	211.87%																											
2.2.	Хөрвөх чадвар болон санхүүгийн нөөц, боломжийн үзүүлэлт																											
2.3.	<p>Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гадаад, дотоод орчноос үзүүлж буй нөлөөлөл, үйл ажиллагаа явуулж буй салбарт эзлэх хувь, бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрөлд гарч буй өөрчлөлт, хөгжил дээрх өөрчлөлтөд үнэт цаас гаргагчийн зүгээс авч хэрэгжүүлэхээр төлөвлөж буй арга хэмжээний мэдээлэл</p>	<p>2023 онд эдийн засгийн сэргэлт идэвхжиж 7%-ийн өсөлттэй гарсан, өрхийн дундаж орлого 23.8%-иар, улсын дундаж цалин 42.1%-иар нэмэгдсэн, инфляци, ажилгүйдлийн түвшин буурсан зэрэг нь өрхийн санхүүгийн байдал болоод ипотекийн зээлийн төлөх чадамж, орон сууц худалдан авах чадамжид эергээр нөлөөлөхөөр байна. Мөн 2023 онд Банк, санхүүгийн салбар өсөлттэй байсантай холбоотой Компанийн харилцагч талын эрсдэлийг бууруулж байна.</p> <p>2023 оны 12 сарын байдлаар орон сууцны үнийн индекс 1.259 болж, өмнөх оны мөн үеэс 0.3 хувиар буурсан ба сүүлийн 2-3 жилд огцом өссөн орон сууцны үнийн индексийн (ОСҮИ) өсөлт тогтворжиж эхлээд байна.</p> <p>Орон сууцны үнэ өссөн ч орон сууцны эрэлт өндөр хэвээр байгаа нь Монгол улсын хүн амын бүтцэд залуучуудын эзлэх хувь их байгаа болон гэр хорооллыг</p>																										

		<p>дахин төлөвлөх, орон нутгийг орон сууцжуулах хэрэгцээ байсаар байгаатай холбоотой.</p> <p>2023 онд 21.2 мянган айлын орон сууцыг ашиглалтад оруулсан ба энэ нь өмнөх оноос 14.3%-иар буурсан, 2021 оноос 26.0%-иар өссөн үзүүлэлт юм. Барилгын салбарын үйлдвэрлэл 2023 онд 0.6%-иар өссөн байдалтай байна.</p> <p>Улаанбаатар хотын агаар, хөрс, усны бохирдлыг бууруулахын тулд гэр хорооллыг дахин төлөвлөх, орон нутгийг орон сууцжуулах нь тулгамдсан асуудлуудын нэг болоод байна. Түүнчлэн Дэлхий нийтийн тогтвортой хөгжил, Байгаль орчин, нийгмийн засаглалын чиг хандлагын хүрээнд тогтвортой хөгжлийн санхүүжилт нэмэгдсэнтэй холбоотойгоор “МИК ОССК” ХХК нь “Тогтвортой хөгжлийн бодлого”-ыг батлан ногоон орон сууцны хөрөнгө, байгууламжуудыг үнэт цаасжуулах, гэр хорооллыг орон сууцжуулах, иргэдийн орлогод нийцсэн зээлийн бүтээгдэхүүнүүдийг төрөлжүүлэх, жендерийн эрх тэгш байдлыг нэмэгдүүлэх зэрэг зорилтуудыг тавин ажиллаж байна.</p> <p>Монгол Улс хүн амын насжилт залуу, социал орчинд идэвхтэй, ухаалаг утасны хэрэглээ өндөр, төрийн болон бусад цахим үйлчилгээнүүд нэмэгдэж байгаа энэ үед Компани хэрэглэгч, зээлдэгчдийн ажиллагааг хөнгөвчилж барьцаа хөрөнгийг цахимаар чөлөөлөх, зээлдэгчийн зарим хүсэлтийг цахимаар шийдвэрлэж ажлыг эхлүүлсэн. Мөн дотоод үйл ажиллагаандаа цахим хэрэгсэл, инновацыг нэвтрүүлж эхэлсэн бөгөөд энэ ажлын хүрээнд санхүүгийн системийн шинэчлэл, багц худалдан авах үйл ажиллагааг цахимжуулах, business intelligence tools нэвтрүүлэхээр ажиллаж байна.</p> <p>2023 оны эцсийн байдлаар Засгийн газрын орон сууцны ипотекийн зээлийн хөтөлбөр (“ЗГОСИЗХ” эсхүл “Хөтөлбөр”)-ийн хүрээнд олгосон ипотекийн зээлийн нийт үлдэгдэл 5.2 их наяд төгрөг, зээлдэгчдийн тоо 85.9 мянгад хүрсэн байна. “МИК</p>
--	--	--

	<p>ОССК” ХХК нь уг зээлийн 78.3%-ийг худалдан авч үнэт цаасжуулсан байгаа бөгөөд энэ нь өмнөх оны мөн үеэс 5.8 нэгж хувиар өссөн үзүүлэлт юм.</p> <p>2023 онд ЗГОСИЗХ-ийн хүрээнд 885.2 тэрбум төгрөгийн зээл, банкны болон бусад эх үүсвэрээр 1.1 их наяд төгрөгийн зээл, нийт 2.0 их наяд төгрөгийн ипотекийн зээл шинээр олгосон ба энэ нь 2022 оноос 45.3%-иар өссөн үзүүлэлт байна. Хөтөлбөрийн зээлийн олголт 24.2%-иар өсөхөд хөтөлбөрийн зээлийн төлбөрийн хойшлуулалт зогссон, ИЗББ гаргалт нэмэгдсэн зэрэг нь эергээр нөлөөллөө. Зээлийн хойшлуулалтын хөтөлбөрийн хүрээнд “МИК ОССК” ХХК нь давхардсан тоогоор 190.5 мянган зээлдэгчийн 10.1 их наяд төгрөгийн зээлийн төлбөрийг хойшлуулсан. Зах зээлийн хүүтэй ипотекийн зээл 67.3%-иар өссөн нь ипотекийн зээлийн нийлүүлэлт өссөн, эрэлт өндөр байгааг харуулж байгаа ба ипотекийн зээлийн зах зээлийн өсөлтөд эергээр нөлөөлж байна.</p> <p>“МИК ОССК” ХХК нь 2024 онд 500 тэрбум төгрөг хүртэлх дүн бүхий ипотекийн зээлийг багцлан худалдан авч үнэт цаасжуулахаар төлөвлөж байна.</p> <p>2023, 2024 оны “Төрөөс баримтлах мөнгөний бодлого”-д Хөнгөлөлттэй хүүтэй ипотекийн зээлийн хөтөлбөрийг Монгол банкнаас Засгийн газарт шилжүүлэхээр тусгасан ба “МИК ОССК” ХХК нь Хөнгөлөлттэй хүүтэй ипотекийн зээлийн хөтөлбөр тогтвортой, үр ашигтайгаар үргэлжлэхэд Засгийн газартай хамтран ажиллана.</p> <p>2023 онд “МИК ОССК” ХХК-ийн худалдан авч багцалдаг Хөтөлбөрийн ипотекийн зээлийн бүтээгдэхүүний нөхцөлд дараах өөрчлөлтүүд орсон байна.</p> <ul style="list-style-type: none">• Зээлийн хэмжээ орон нутагт 150 сая төгрөг болсон.• Орон нутагт даатгагч зээлийн урьдчилгаа төлбөрт батлан даалт гаргах боломжтой болсон.
--	--

		<ul style="list-style-type: none"> • Мөн 2023 онд хэрэгжсэн Орон нутаг болон алслагдмал дүүргүүдэд худалдан авах орон сууцны урьдчилгаа төлбөрийн 60%-д баталгаа гаргах, 3%-ийн хүүгийн татаас олгох зэрэг ажиллагааг үргэлжлүүлэн хэрэгжүүлэхээр 2024 оны төсөвт тусгасан. <p>2024 оны төсөвт орон нутгийн хөгжлийг дэмжих, төвлөрлийг сааруулах бодлогын хүрээнд ипотекийн зээлийн санхүүжилтийн 50%-ийг орон нутагт олгох, орон нутагт шинээр барьсан нийтийн зориулалттай орон сууц борлуулсны орлогод ногдох албан татварыг хөнгөлөх гэх мэт арга хэмжээнүүдийг тусгасан. Дээрх өөрчлөлтүүд нь орон нутагт ипотекийн зээлийн санхүүжилтийг нэмэгдүүлэх, барилгын ажлыг эрчимжүүлэх ач холбогдолтой.</p> <p>Компани Эрсдэлийн удирдлагын тогтолцооны ISO31000:2018 стандарт, СТОУС9, Мэдээллийн аюулгүй байдлын ISO/IEC27001:2013 стандарт, Хамгаалалтын гурван шугам загвар, олон улсын мэргэжлийн байгууллагын зөвлөмж болон олон улсын тэргүүн туршлагуудын хүрээнд хэрэгжүүлж ажилладаг ба 2023 онд Комплайнсын ISO 31000:2018 стандартыг компанийн үйл ажиллагаанд нэвтрүүлснийг хөндлөнгийн мэргэжлийн байгууллагаар баталгаажуулсан.</p> <p>2024 оны 1 сард “МИК ОССК” ХХК нь 11.5%-ийн хүүтэй, 3 жилийн хугацаатай, 225 сая ам.долларын дүн бүхий Хулан бондыг олон улсын зах зээл дээр амжилттай арилжаалсан.</p>
2.4.	Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, нягтлан бодох бүртгэлийн бодлогын мэдээлэл /off balance/	Балансын гадуур үлдэгдлийн тайлан , НББ-ийн бодлого хавсаргав.
2.5.	Тайлант хугацаанд авсан зээлийн эргэн төлөлт болон зээлийн барьцаа, баталгааны талаарх мэдээлэл;	Засгийн газрын 2023 оны “Хот, хөдөөгийн сэргэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 68 дугаар тогтоолын дагуу Монголбанк, Барилга хот байгуулалтын яам, Зээлийн батлан даалтын сан болон



		<p>Арилжааны банкууд “Ипотекийн зээл”-ийн орон нутгийн орон сууцны санхүүжилтийн ерөнхий гэрээ байгуулсан.</p> <p>Тус гэрээний дагуу банкууд орон нутагт болон алслагдсан дүүргүүдэд (Налайх, Багануур, Багахангай) урьдчилгаа төлбөрийн батлан даалттай ипотекийн зээлүүдийг олгож эхэлсэн.</p> <p>Бид 2023 онд Орон сууцны ипотекийн зээлийн хөтөлбөрийн хүрээнд 1.1 их наяд төгрөгийн ипотекийн зээлээр баталгаажсан бонд гаргасан бөгөөд үүнээс 1.3 тэрбум төгрөгийн 14 зээл нь урьдчилгаа төлбөрийн батлан даалттай зээл байна.</p>																																														
3.	<p>Үнэт цаас гаргагчийн тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцлийн мэдээлэл, хэлцэл хийх ач холбогдол зорилго, сонирхлын зөрчилтэй этгээдийн талаарх мэдээлэл /тайлант хугацаанд хийгдсэн нийт сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээллийг тусгана/</p>																																															
	<table border="1"> <tr><td>1</td><td>1/17/2023</td><td>Хуулийн этгээдийн мөнгөн хадгаламжийн гэрээ</td><td>Худалдаа хөгжлийн банк</td><td>Хадгаламж байршуулах</td></tr> <tr><td>2</td><td>2/27/2023</td><td>Хуулийн этгээдийн мөнгөн хадгаламжийн гэрээ</td><td>Худалдаа хөгжлийн банк</td><td>Хадгаламж байршуулах</td></tr> <tr><td>3</td><td>5/2/2023</td><td>Хуулийн этгээдийн мөнгөн хадгаламжийн гэрээ</td><td>Худалдаа хөгжлийн банк</td><td>Хадгаламж байршуулах</td></tr> <tr><td>4</td><td>6/14/2023</td><td>Хуулийн этгээдийн мөнгөн хадгаламжийн гэрээ</td><td>Худалдаа хөгжлийн банк</td><td>Хадгаламж байршуулах</td></tr> <tr><td>5</td><td>7/19/2023</td><td>Хуулийн этгээдийн мөнгөн хадгаламжийн гэрээ</td><td>Худалдаа хөгжлийн банк</td><td>Хадгаламж байршуулах</td></tr> <tr><td>6</td><td>8/24/2023</td><td>Хуулийн этгээдийн мөнгөн хадгаламжийн гэрээ</td><td>Худалдаа хөгжлийн банк</td><td>Хадгаламж байршуулах</td></tr> <tr><td>7</td><td>11/22/2023</td><td>Хуулийн этгээдийн мөнгөн хадгаламжийн гэрээ</td><td>Худалдаа хөгжлийн банк</td><td>Хадгаламж байршуулах</td></tr> </table>	1	1/17/2023	Хуулийн этгээдийн мөнгөн хадгаламжийн гэрээ	Худалдаа хөгжлийн банк	Хадгаламж байршуулах	2	2/27/2023	Хуулийн этгээдийн мөнгөн хадгаламжийн гэрээ	Худалдаа хөгжлийн банк	Хадгаламж байршуулах	3	5/2/2023	Хуулийн этгээдийн мөнгөн хадгаламжийн гэрээ	Худалдаа хөгжлийн банк	Хадгаламж байршуулах	4	6/14/2023	Хуулийн этгээдийн мөнгөн хадгаламжийн гэрээ	Худалдаа хөгжлийн банк	Хадгаламж байршуулах	5	7/19/2023	Хуулийн этгээдийн мөнгөн хадгаламжийн гэрээ	Худалдаа хөгжлийн банк	Хадгаламж байршуулах	6	8/24/2023	Хуулийн этгээдийн мөнгөн хадгаламжийн гэрээ	Худалдаа хөгжлийн банк	Хадгаламж байршуулах	7	11/22/2023	Хуулийн этгээдийн мөнгөн хадгаламжийн гэрээ	Худалдаа хөгжлийн банк	Хадгаламж байршуулах												
1	1/17/2023	Хуулийн этгээдийн мөнгөн хадгаламжийн гэрээ	Худалдаа хөгжлийн банк	Хадгаламж байршуулах																																												
2	2/27/2023	Хуулийн этгээдийн мөнгөн хадгаламжийн гэрээ	Худалдаа хөгжлийн банк	Хадгаламж байршуулах																																												
3	5/2/2023	Хуулийн этгээдийн мөнгөн хадгаламжийн гэрээ	Худалдаа хөгжлийн банк	Хадгаламж байршуулах																																												
4	6/14/2023	Хуулийн этгээдийн мөнгөн хадгаламжийн гэрээ	Худалдаа хөгжлийн банк	Хадгаламж байршуулах																																												
5	7/19/2023	Хуулийн этгээдийн мөнгөн хадгаламжийн гэрээ	Худалдаа хөгжлийн банк	Хадгаламж байршуулах																																												
6	8/24/2023	Хуулийн этгээдийн мөнгөн хадгаламжийн гэрээ	Худалдаа хөгжлийн банк	Хадгаламж байршуулах																																												
7	11/22/2023	Хуулийн этгээдийн мөнгөн хадгаламжийн гэрээ	Худалдаа хөгжлийн банк	Хадгаламж байршуулах																																												
4.	Цалин урамшууллын мэдээлэл																																															
	<p>ТУЗ-ийн гишүүдийн цалинг дараах байдлаар 2023 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас баталсан байна.</p> <table border="1"> <thead> <tr> <th rowspan="3">Зардлын төрөл</th> <th rowspan="3">Давтамж</th> <th rowspan="3">Хүний тоо</th> <th colspan="4">Үүнээс:</th> </tr> <tr> <th colspan="2">2023/05/01-2023/12/31</th> <th colspan="2">2024/01/01-2024/04/30</th> </tr> <tr> <th>суурь</th> <th>нэмэгдэл</th> <th>суурь</th> <th>нэмэгдэл</th> </tr> </thead> <tbody> <tr> <td></td> <td></td> <td></td> <td></td> <td></td> <td></td> <td></td> <td></td> <td></td> <td></td> <td></td> <td></td> <td></td> <td></td> <td></td> </tr> </tbody> </table>														Зардлын төрөл	Давтамж	Хүний тоо	Үүнээс:				2023/05/01-2023/12/31		2024/01/01-2024/04/30		суурь	нэмэгдэл	суурь	нэмэгдэл																			
Зардлын төрөл	Давтамж	Хүний тоо	Үүнээс:																																													
			2023/05/01-2023/12/31		2024/01/01-2024/04/30																																											
			суурь	нэмэгдэл	суурь	нэмэгдэл																																										

Цалин	12	9	50,400,000	36,000,000	25,200,000	18,000,000
ТУЗ-ийн гишүүн	12	9	50,400,000	36,000,000	25,200,000	18,000,000
НДШ	12	9	6,199,200	4,428,000	3,099,600	2,214,000
Нийт зардал	12	9	56,599,200	40,428,000	28,299,600	20,214,000

ТУЗ-ийн гишүүний цалин тооцох аргачлалын тухай

ТУЗ-ийн гишүүнд олгох цалин нь суурь болон нэмэгдэл цалингаас бүрдэнэ. Суурь цалин нь ТУЗ-ийн гишүүнээс томилогдон ажиллаж байгаагийн хувьд сар бүр олгогдох тогтмол цалин бөгөөд нэмэгдэл цалинг хуралд оролцсон оролцоо тус бүрээр тооцон улиралд нэг удаа олгодог.

Цалинг олгохдоо зохих татвар, суутгалыг суутган олгодог.

Гүйцэтгэх захирлын цалин урамшууллын тухай

Гүйцэтгэх захиралтай байгуулсан гэрээний дагуу цалин урамшууллын хэмжээг ТУЗ-өөс тогтоодог.

Компанийн ашигтай ажиллуулсан тухай жилийн компанийн ашигт ажиллагааны түвшин, компанийн үйл ажиллагааны өсөлт, төлөвшил, эрсдэлийг бууруулах талаах хийсэн ажил, хүрсэн үр дүн зэргийг нь харгалзан ТУЗ нь Гүйцэтгэх удирдлагад урамшуулал олгож болно.

5. Компанийн засаглалтай холбоотой мэдээлэл

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал

“МИК Холдинг” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 3 дугаар сарын 17-ны өдрийн 23/08 дугаартай тогтоолын дагуу Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг Монгол Улсын *Компанийн тухай хууль*, Санхүүгийн зохицуулах хорооны *Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журмыг* баримтлан 2023 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн 11:00 цагаас live.mik.mn сайтаар дамжуулан цахимаар хуралдууллаа.

Тус хурлыг ТУЗ-ийн даргын үүргийг орлон гүйцэтгэгч, хараат бус гишүүн Чулуундоржийн Хашчулуун удирдан явуулсан. Хуралд тооллогын комисс, хурал зохион байгуулах комисс болон компанийн жилийн эцсийн санхүүгийн тайланд аудитын дүгнэлт гаргасан “Эрнст энд Янг Монголиа аудит ХХК-ийн төлөөлөл оролцсон бөгөөд саналын эрхтэй хувьцааны 94.03 хувийн ирцтэйгээр хуралдсан.

Төлөөлөн удирдах зөвлөлийн хурал

“МИК Холдинг” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурал нийт 8 удаа хуралдаж Компанийн засаглалын баримт бичгийг батлах, Санхүүгийн тайланг хэлэлцэх, Аудитын үйлчилгээний гэрээ байгуулах, Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал зарлан хуралдуулах, Бизнес төлөвлөгөө батлах, ТУЗ-ийн үнэлгээ зохион байгуулах, Баталгаа гаргах зэрэг нийт 17 шийдвэр гарсан.

6. Зах зээлийн эрсдэлийн мэдээлэл



i. Валютын ханшийн эрсдэл

Компани валютын ханшийн эрсдэлийн үнэлгээнд VAR аргачлалыг ашиглан, ханшийн өөрчлөлтөөс хүлээж болзошгүй алдагдал нийт өөрийн хөрөнгийн 15%-с хэтрэхгүй байх шалгуурыг тавьдаг бөгөөд сар бүр ханшийн эрсдэлийн шинжилгээг хийж, холбогдох газар нэгжүүд болон удирдлагыг мэдээллээр ханган ажиллаа. Валютын ханшийн эрсдэлийг гуравдагч этгээдэд шилжүүлэх буюу своп хэлцэл хийх байдлаар бууруулж ажиллаж байгаа бөгөөд тайлант хугацаанд компани дээр дурдсан шалгуурыг хангаж ажилласан байна.

ii. Хөрвөх чадварын эрсдэл

Хөрвөх чадварын эрсдэлийг түргэн хөрвөх хөрөнгийн харьцаа болон төлбөр гүйцэтгэх чадварын харьцаа үзүүлэлтээр хэмжиж байна. Түргэн хөрвөх хөрөнгийн харьцааг тооцохдоо ирэх 30 хоногийн нийт цэвэр гарах мөнгөн урсгалыг өндөр хөрвөх чадвартай хөрөнгөд харьцуулдаг бөгөөд уг харьцаа нь 100%-иас их байх шалгуурыг тавьж байна. МИК ОССК-ийн хувьд түргэн хөрвөх хөрөнгийн харьцааны шалгуурыг хангаж ажиллаж байгаа бөгөөд цаашид тухайн жилийн Эрсдэлийн аппетитаар тогтоосон эрсдэлийн зорилтот түвшин, анхааруулах түвшин болон дээд түвшинтэй уялдуулан хяналт тавьж ажиллалаа.

Төлбөр гүйцэтгэх чадварын харьцааг хөрвөх чадварын зөрүүгийн тайлан, түүний хугацааны интервалын үзүүлэлтүүдэд үндэслэнэ. Шалгуур үзүүлэлтийг нийт хугацааны интервалаарх цэвэр хөрвөх чадварын зөрүүний өсөн нэмэгдсэн дүн 0-ээс их байна гэж зааж өгсөн ба уг үзүүлэлтийг ханган ажиллаж байна.

iii. Хүүгийн эрсдэл

Хүүгийн эрсдэлийг хөвөгч хүүтэй актив пассивын зөрүү болон хүү олдог актив болон хүүгийн зардал гардаг пассивын зөрүүгээр тооцоолдог бөгөөд уг үзүүлэлтүүдэд сар бүр шинжилгээ хийж, холбогдох газар нэгжүүд болон удирдлагуудад мэдээлэл, зөвлөмжөөр ханган ажиллаа.

7.

Хувьцаа эзэмшигчдийн өмчлөлийн мэдээлэл /5 ба түүнээс дээш хувьцаа эзэмшигчдийн нэрс эзэмшлийн хувь, нийт хувьцаа эзэмшигчдийн тоо/

“МИК Холдинг” ХК-ийн нийт хувьцааны 17.23 хувийг төрийн өмчит эзэмшил байгууллагууд, 82.68 хувийг банк болон хувийн хэвшлийн байгууллагууд, 0.09 хувийг иргэд эзэмшиж байгаа бөгөөд 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар нийт 215 хувьцаа эзэмшигчтэй байна.

Хувьцаа эзэмшигчдийн өмчлөлийн мэдээлэл / Нөлөө бүхий хувьцаа эзэмшигчид/

№	Хувьцаа эзэмшигчдийн нэрс	Хувьцааны тоо ширхэг	Хувь хэмжээ
1	Монгол Улсын хөгжлийн банк	3,081,955	14.88 %
2	Си Эн Би Консалтинг ХХК	2,608,480	12.60%
3	Азиа Дайверсифайд Рийл Истэйт Фанд Нэг Хувийн ХОС	2,312,500	11.17%
4	Худалдаа хөгжлийн банк	2,070,932	10.00 %
5	Ти Ди Би Капитал ХХК	1,232,785	5.95%

	6 Ти Ди Би Секьюритиз ХХК	1,097,953	5.30 %
8.	Үнэт цаас гаргагч нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор нийтэд санал болгон хувьцаа гаргасан бол төсөл хэрэгжиж эхэлснээс хойш дуусах хүртэл хугацаанд төслийн хэрэгжилтийн явц болон татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан мэдээлэл		
	Байхгүй		
9.	Ногдол ашгийн мэдээлэл		
	Компани нь олон улсын зах зээлд бонд гаргасантай холбоотой олон улсын хөрөнгө оруулагч нарын өмнө хүлээсэн үүргийн дагуу гэрээнд заасан нөхцөл болон “Ногдол ашгийн бодлого”-ын 3.3 дахь “ТҮЗ-ийн шийдвэрээр тодорхой хугацаанд ногдол ашиг хуваарилахгүй байж болно” гэсэн заалтыг үндэслэн ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсэн.		
10.	Үнэт цаас гаргагчаас тайланд хугацаанд нийгмийн хариуцлагын чиглэлээр хийгдсэн ажлын тайлангийн мэдээлэл		
	<p>Улсын төв нэгдүгээр эмнэлэгт дотрын эхоны аппарат хандивлав.</p> <p>Иргэдийн эрүүл мэндийг хамгаалахтай холбогдуулан үзлэг, оношилгоо хийх тоног төхөөрөмжийг шинэчлэх зорилгоор Гастроэнтрологийн төвийн 50 жилийн ойг тохиолдуулан Компаниас нийгмийн хариуцлагын хүрээнд 20 жил ашигласан эхо аппаратыг шинэчилж, 86.5 сая төгрөгийн үнэ бүхий хамгийн сүүлийн үеийн “D60” эхо аппаратыг улсын төв нэгдүгээр эмнэлэгт хандивласан. Тус эхо аппарат нь иргэд үзүүлэх, эмч үзлэг хийхэд илүү хялбар болж, элэгний хүнд өвчний оношилгоо болон ажилбар хийхэд чанар сайжрах, гаж нөлөө, эрсдэл буурах зэрэг ач холбогдолтой юм.</p> <p>Өндөр гэгээний өвийг хамгаалах төслийг хэрэгжүүлэв.</p> <p>МИК нь компанийн нийгмийн хариуцлагын хүрээнд цаг хугацаа, түүхийн сорилыг давж ирсэн соёлын өвийг хамгаалах, сэргээн засварлах, хойч үедээ өвлүүлэн үлдээхэд чиглэсэн төсөл хөтөлбөрүүдийг дэмжин ажилладаг. 2023 онд Монголын Төр, Шашны Тэргүүн 1-р Богд Хаан, Өндөр Гэгээн Занабазарын бүтээсэн Буддын урлагийн түүхийн охь болсон бүтээлүүдийг анх удаа нэг дор олон нийтийн хүртээл болго “Өндөр гэгээн Занабазарын 21 дарь эхийн чуулган” үзэсгэлэн болон “Өндөр Гэгээний өв” номыг ивээн тэтгэж, Богд Хааны Ордон музейн хамт олонтой хамтран ажиллалаа.</p> <p>МИК-ийн төгөл байгууллаа.</p> <p>Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан Тэрбум мод үндэсний хөдөлгөөнд нэгдсэн цагаас хойш мод тарих үйл ажиллагаанд идэвхтэй оролцож байна. МИК нь нийгмийн хариуцлагын хүрээнд 2023 оны хавар, намар үндэсний мод тарих өдрүүдэд 36 байршилд, 20 гаруй төрлийн нийт 3200 гаруй мод тариалаа.</p> <p>Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан Тэрбум мод үндэсний хөдөлгөөнд нэгдсэн цагаас хойш мод тарихад идэвхтэй оролцож, тайланд жилийн хугацаанд дараах байршлуудад мод тариалаа.</p> <ul style="list-style-type: none"> • 2023.5.13. Мод тарих үндэсний өдөр хоёр байршилд зэрэг мод тариалаа. СЗХ-оос зохицуулалтын 16 байгууллагын дунд санаачилсан СХД-ийн 21-р хороон дахь “Инcheon Мөрөөдлийн төгөл”-д мод 		



тарих уриалгад нэгдэн оролцож, хувь нэмрээ оруулсан бол “AmCham Mongolia”-с зохион байгуулсан Үндэсний цэцэрлэгт хүрээлэнд мод тарих үйл ажиллагаанд нэгдлээ.

- 2023.10.01-06. Намрын мод тарих өдрийг тохиолдуулан ажилтнууд өөрийн зуслангийн газар, хашаандаа мод тарихад мэргэжлийн байгууллагын зөвлөгөө, сургалт авч модны суулгац зэргээр дэмжлэг үзүүлэв. Үүнд 20 орчим ажилтан хамрагдаж, 11 нэр төрлийн 200 модыг тарьж, өдөр тутам арчлан ургуулж байна.
- 2023.10.07. СЗХ-оос зохион байгуулсан намрын мод тарих аянд МИК-ийн төлөөлөл оролцож, Өвөрхангай аймгийн Хархорин суманд 2000 ширхэг мод тарилаа.
- 2023.10.26. Сэлэнгэ аймгийн Баянгол сумын нутагт хөрсний доройтолд орсон газрыг нөхөн сэргээх зорилготой “МИК ТӨГӨЛ”-ийг байгуулж, тус төглийг тогтмол арчилж, өсгөн үржүүлэхээр боллоо.

Мэдээлэл гаргагч этгээд болон мэдээллийн үнэн зөвийг баталсан этгээдийн гарын үсэг, огноо:

Овог, нэр: Б.Гантулга

Албан тушаал: МИК Холдинг ХК-ийн Гүйцэтгэх захирал

Гарын үсэг:



Мэдээлэл бэлтгэж, хүргүүлсэн этгээдийн гарын үсэг, огноо:

Овог, нэр: Г.Саруул

Албан тушаал: ТУЗ-ийн нарийн бичгийн дарга

Гарын үсэг: Г.Саруул

МИК ХОЛДИНГ ХК
(МОНГОЛ УЛСАД БҮРТГЭЛТЭЙ АЖ АХУЙН НЭГЖ)

Аудитлагдсан санхүүгийн тайлан
2023 оны 12 дугаар сарын 31



МИК ХОЛДИНГ ХК

2023 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НЭЭР ДУУСГАВАР БОЛСОН ТАЙЛАНТ ЖИЛ

АГУУЛГА

Компанийн мэдээлэл	1
Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга ба гүйцэтгэх удирдлагын мэдэгдэл.....	2
Хараат бус аудиторын тайлан	3-4
Ашиг алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайлан	5
Санхүүгийн байдлын тайлан	6
Өмчийн өөрчлөлтийн тайлан	7
Мөнгөн гүйлгээний тайлан	8
Санхүүгийн тайлангийн тодруулгууд.....	9-27

МИК ХОЛДИНГ ХК

Компанийн мэдээлэл

Албан хаяг

: Монгол Улс, Улаанбаатар хот 15160,
Чингэлтэй дүүрэг, 1-р хороо,
Д.Сүхбаатарын талбай гудамж 11

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд

: Ч. Хашчулуун (ТУЗ-ийн даргын үүрэг гүйцэтгэгч)
Т. Даваажав
А. Энхжин
Л. Тэмүүжин
Б. Үүрцайхбаатар
Н. Сэргэлэн
Э. Шижир
Ө. Ганзориг
М. Мөнхбаатар

Нарийн бичгийн дарга

: Г. Саруул

Аудиторууд

: Эрнст энд Янг Монголия Аудит ХХК
Мэргэшсэн нягтлан бодогчид

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА БА ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГЫН МЭДЭГДЭЛ

МИК Холдинг ХК (цаашид хамтад нь “Компани” гэх)-ын Төлөөлөн Удирдах Зөвлөл (“ТУЗ”)-ийн даргын үүрэг гүйцэтгэгч Чулуундоржийн Хашчулуун, Гүйцэтгэх захирал Бадамхатангийн Гантулга болон Үйл ажиллагаа хариуцсан дэд захирал Ганбаатарын Сансар, бид Компанийн санхүүгийн тайлангууд нь 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх Компанийн санхүүгийн байдал хийгээд тухайн өдрөөр дуусгавар болсон санхүүгийн жилийн үйл ажиллагааны нэгтгэсэн үр дүн, мөнгөн гүйлгээг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөл (“НББОУСЗ”)-өөс баталж гаргасан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартууд (“СТОУС”)-ын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлсэн гэдгийг үүгээр мэдэгдэж байна.



Чулуундоржийн Хашчулуун
ТУЗ-ийн даргын үүрэг гүйцэтгэгч

Бадамхатангийн Гантулга
Гүйцэтгэх захирал

Ганбаатарын Сансар
Үйл ажиллагаа хариуцсан дэд
захирал

Монгол Улс, Улаанбаатар хот

Огноо: 2024.03.13

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

МИК Холдинг ХК-ийн Хувьцаа эзэмшигчдэд

Дүгнэлт

Бид МИК Холдинг ХК (цаашид “Компани” гэх)-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх Компанийн санхүүгийн байдлын тайлан, тухайн өдрөөр дуусгавар болсон санхүүгийн жилийн ашиг, алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо болон бусад тайлбар тодруулгуудаас бүрдсэн санхүүгийн тайлангуудад аудит хийж гүйцэтгэлээ.

Бидний дүгнэлтээр дээр нэрлэсэн санхүүгийн тайлангууд нь 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх Компанийн санхүүгийн байдал хийгээд тухайн өдрөөр дуусгавар болсон санхүүгийн жилийн үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөл (“НББОУСЗ”)–өөс баталж гаргасан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартууд (“СТОУС”)–ын дагуу материаллаг алдаагүй, бодитойгоор илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын олон улсын стандарт (“АОУС”)–уудын дагуу хийж гүйцэтгэлээ. Уг стандартуудын дагуу хүлээсэн үүрэг хариуцлагуудыг энэхүү тайлангийн “Санхүүгийн тайлангийн аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага” хэсэгт харуулав. Бид Нягтлан бодогчдын ёс зүйн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан “Мэргэжсэн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм”-ийн дагуу Компаниас хараат бус бөгөөд уг дүрэмд заасны дагуу өөрсдийн бусад ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Бидний олж авсан аудитын нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтэд хангалттай, зохистой үндэслэл болж чадна гэдэгт бид итгэлтэй байна.

Санхүүгийн тайлангуудтай холбоотойгоор удирдлага болон засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдийн хүлээх хариуцлага

Санхүүгийн тайлангуудыг СТОУС–ын дагуу бэлтгэх, бодитойгоор илэрхийлэх ба залилан, алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэх боломжийг бий болгоход шаардлагатай гэж удирдлагын тодорхойлсон дотоод хяналтуудад удирдлага хариуцлага хүлээнэ.

Компанийн удирдлага нь санхүүгийн тайлангуудыг бэлтгэхдээ Компанийн үйл ажиллагааг зогсоох эсвэл татан буулгахаар төлөвлөсөн эсвэл эдгээрээс өөр бодит сонголт байхгүйгээс бусад тохиолдолд санхүүгийн тайлангуудыг бэлтгэхдээ удирдлага нь тасралтгүй байх зарчмын дагуу Компанийн үйл ажиллагааг тасралтгүй явуулах чадварыг үнэлэх, боломжтой бол тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэгтэй. Засаглал хариуцсан этгээдүүд нь Компанийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэгтэй.

Санхүүгийн тайлангийн аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага

Залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан нь бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаа олж авах, дүгнэлт бүхий аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм.

Зохистой баталгаажуулалт гэдэг нь өндөр түвшний баталгаажуулалт боловч “АОУС”–ын дагуу хийгдсэн аудит нь оршин байгаа материаллаг буруу илэрхийллийг байнга илрүүлнэ гэсэн баталгаа биш юм. Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох ба хэрэв тэдгээр нь дангаараа эсвэл нийтдээ санхүүгийн тайланд үндэслэн гаргасан хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллагт тооцогдоно.

“АОУС”–ын дагуу хийх аудитын үед бид мэргэжлийн үнэлэмж, мэргэжлийн үл итгэх зарчмыг баримтлан ажилладаг. Бид мөн:

- Залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох санхүүгийн тайлангийн материаллаг буруу илэрхийллийн эрсдэлүүдийг таних, үнэлэх, тэдгээр эрсдэлд тохирох аудитын горимуудыг боловсруулах, гүйцэтгэх, өөрсдийн дүгнэлтэд үндэслэл болохуйц хангалттай, зохистой аудитын нотолгоог олж авах. Залилан нь хуйвалдах, бичиг баримт хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу мэдэгдэл хийх, дотоод хяналтыг зөрчих зэрэг үйлдлүүдтэй холбоотой байж болох тул залилангаас үүдэн гарсан материаллаг буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас үүдэн гарсан буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэлээс өндөр байдаг.
- Компанийн дотоод хяналтын үр нөлөөтэй байдалд дүгнэлт өгөх зорилгоор биш тухайн нөхцөл байдалд тохирохуйц аудитын горим боловсруулахын тулд аудитад хамааралтай дотоод хяналтын талаар ойлголт олж авах.

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН (ҮРГЭЛЖЛЭЛ)

МИК Холдинг ХК-ийн Хувьцаа эзэмшигчдэд (үргэлжлэл)

Санхүүгийн тайлангийн аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага (үргэлжлэл)

- Хэрэглэсэн нягтлан бодох бүртгэлийн бодлогууд нь зохистой эсэх, удирдлагын зүгээс нягтлан бодох бүртгэлийн ойролцоолсон тооцооллууд, тэдгээрт холбогдох тодруулгууд нь үндэслэлтэй эсэхийг үнэлэх.
- Нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг удирдлага зохистой хэрэглэсэн эсэх, олж авсан аудитын нотолгоонд үндэслэн Компанийн үйл ажиллагаагаа тасралтгүй явуулах чадамжид мэдэгдэхүйц эргэлзээ үүсгэж болох үйл явдал эсвэл нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал байгаа эсэхийг дүгнэх. Хэрэв материаллаг тодорхой бус байдал байна гэж дүгнэвэл, бид аудиторын тайландаа санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгыг хийж өгөх эсвэл ийм тодруулга хангалтгүй бол дүгнэлтээ өөрчлөх шаардлагатай болдог. Аудиторын тайлан гарах өдөр хүртэл олж авсан аудитын нотолгоонд үндэслэн бид дүгнэлтээ гаргадаг. Гэхдээ ирээдүйн үйл явдал эсвэл нөхцөл байдал Компанийн тасралтгүй байх зарчмыг алдагдуулж болно.
- Санхүүгийн тайлангууд (үүнд тодруулгууд багтана)-ын ерөнхий толилуулга, бүтэц, агуулгыг үнэлэх мөн санхүүгийн тайлангууд нь илэрхийлэгдэх шаардлагыг хангахуйц байдлаар холбогдох ажил гүйлгээ, үйл явдлуудыг илэрхийлсэн эсэхийг үнэлэх.


Бид аудитын ажлын төлөвлөсөн хамрах хүрээ, цаг хугацаа, томоохон хэмжээний дутагдал болон аудитын явцад олж тогтоосон дотоод хяналтын томоохон доголдол зэргийг багтаасан асуудлыг засаглал хариуцсан этгээдүүдэд мэдэгддэг.

Бусад зүйл

Энэхүү тайланг өөр ямар нэгэн зорилгоор биш, Монгол Улсын "Компанийн тухай хууль"-ийн 94 дүгээр зүйлд заасны дагуу Компанийн хувьцаа эзэмшигчдийн хүсэлтээр аудитыг гүйцэтгэн Компанийн хувьцаа эзэмшигчдэд зориулан гаргалаа. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд аливаа гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй болно.

Ernst & Young Mongolia Audit LLC
ЭРНСТ ЭНД ЯНГ МОНГОЛИЯ АУДИТ ХХК
Мэргэшсэн нягтлан бодогчид

Гарын үсэг зурсан



Доржбатын Мандахбаяр
Партнер

Монгол Улс, Улаанбаатар хот
Огноо: 2024 оны 3 дугаар сарын 18

Баталсан



Вонг Шү Хинг
Партнер

МИК ХОЛДИНГ ХК**2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн****Ашиг, алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайлан**

	Тодруулга	2023 мян.төг	2022 мян.төг
Үр ашигт хүүний аргаар тооцсон хүүний орлого		164,491	88,374
Хураамж, шимтгэлийн орлого	3	3,020,002	3,055,291
Хураамж, шимтгэлийн зардал		(86)	(46)
Бусад орлого		8,225	–
Хүлээгдэж буй үнэ цэнийн бууралтын алдагдлын зардал	4	(574,556)	(863)
Үйл ажиллагааны зардал	5	(1,090,645)	(1,741,525)
Бусад зардал		(6,865)	(2,189)
Татварын өмнөх ашиг		<u>1,520,566</u>	<u>1,399,042</u>
Орлогын албан татварын зардал	6.1	(211,909)	(143,687)
Нийт дэлгэрэнгүй орлогыг илэрхийлэх тайлант жилийн ашиг		<u><u>1,308,657</u></u>	<u><u>1,255,355</u></u>

Хавсаргасан тодруулгууд нь энэхүү санхүүгийн тайлангийн саллигүй хэсэг болно.

МИК ХОЛДИНГ ХК

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх

Санхүүгийн байдлын тайлан

	Тодруулга	2023 мян.төг	2022 мян.төг
ХӨРӨНГӨ			
Бэлэн мөнгө ба банкн дахь харилцах, хадгаламж	7	1,991,953	2,524,669
Бусад хөрөнгө	8	214,960	68,964
Үндсэн хөрөнгө	9	34,390	46,694
Биет бус хөрөнгө	10	11,349	25,611
Охин компаниуд дахь хөрөнгө оруулалт	11	73,075,105	73,075,105
НИЙТ ХӨРӨНГӨ		<u>75,327,757</u>	<u>75,741,043</u>
ӨР ТӨЛБӨР			
Бусад өр төлбөр	12	50,147	170,407
Орлогын албан татварын өр	6.2	91,165	49,121
Санхүүгийн баталгааны гэрээний сан	13	798,875	2,442,602
НИЙТ ӨР ТӨЛБӨР		<u>940,187</u>	<u>2,662,130</u>
ӨӨРИЙН ХӨРӨНГӨ			
Энгийн хувьцаа	14	20,709,320	20,709,320
Нэмж төлөгдсөн капитал	14	52,225,115	52,225,115
Хуримтлагдсан ашиг		1,453,135	144,478
НИЙТ ӨӨРИЙН ХӨРӨНГӨ		<u>74,387,570</u>	<u>73,078,913</u>
НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ӨӨРИЙН ХӨРӨНГӨ		<u>75,327,757</u>	<u>75,741,043</u>

Хавсаргасан тодруулгууд нь энэхүү санхүүгийн тайлангийн саллигүй хэсэг болно.

МИК ХОЛДИНГ ХК**2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн****Өмчийн өөрчлөлтийн тайлан**

	Энгийн хувьцаа мян.төг	Нэмж төлөгдсөн капитал мян.төг	Хуримт- лагдсан ашиг мян.төг	Нийт өөрийн хөрөнгө мян.төг
2022 оны 1 дүгээр сарын 1-ний байдлаар	20,709,320	52,225,115	(1,110,877)	71,823,558
Нийт дэлгэрэнгүй орлого	–	–	1,255,355	1,255,355
2022 оны 12 дугаар сарын 31 болон 2023 оны 1 дүгээр сарын 1-ний байдлаар	20,709,320	52,225,115	144,478	73,078,913
Нийт дэлгэрэнгүй орлого	–	–	1,308,657	1,308,657
2023 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар	<u>20,709,320</u>	<u>52,225,115</u>	<u>1,453,135</u>	<u>74,387,570</u>

Хавсаргасан тодруулгууд нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

МИК ХОЛДИНГ ХК

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн

Мөнгөн гүйлгээний тайлан

	Тодруулга	2023 мян.төг	2022 мян.төг
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ			
Татварын өмнөх ашиг		1,520,566	1,399,042
<i>Мөнгөн бус тохируулгууд:</i>			
Бэлэн мөнгө ба банкн дахь харилцах хадгалмжийн үнэ цэнийн бууралтын эрсдэлийн сангийн буцаалт/(алдагдал)	4	(887)	863
Нөөц сангийн үнэ цэнийн бууралтын эрсдэлийн сангийн зардал	4	575,443	–
Үндсэн хөрөнгийн элэгдэл	5	26,187	31,733
Биет бус хөрөнгийн хорогдол	5	14,262	8,903
<i>Ажлын капиталын өөрчлөлтийн өмнөх үйл ажиллагааны ашиг</i>			
Үйл ажиллагааны хөрөнгө, өр төлбөрийн өөрчлөлтүүд:			
Бусад хөрөнгө		(153,663)	(63,964)
Бусад өр төлбөр		(120,260)	57,324
Нөөц сан		(2,219,170)	(2,659,091)
Үндсэн үйл ажиллагаанд зарцуулсан мөнгөн гүйлгээ		(357,522)	(1,225,190)
Төлсөн татвар	6.2	(145,748)	(93,261)
Бусад суутгуулсан татвар	6.2	(16,450)	–
Үйл ажиллагаанд зарцуулсан цэвэр мөнгөн гүйлгээ		(519,720)	(1,318,451)
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ГҮЙЛГЭЭ			
Үндсэн хөрөнгийн худалдан авалт	9	(13,883)	(34,024)
Биет бус хөрөнгө худалдан авалт	10	–	(34,514)
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанд зарцуулсан цэвэр мөнгөн гүйлгээ		(13,883)	(68,538)
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн цэвэр бууралт		(533,603)	(1,386,989)
1 дүгээр сарын 1-ний өдрөөрх мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө		2,525,610	3,912,599
12 дугаар сарын 31-ний өдрөөрх мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	7	1,992,007	2,525,610
Мөнгөн бус үйл ажиллагаа:			
Бусад татварын өглөгөөр дахин ангилсан		7,667	–

Хавсаргасан тодруулгууд нь энэхүү санхүүгийн тайлангийн салиггүй хэсэг болно.

1. Компанийн мэдээлэл

МИК Холдинг ХК ("Компани") нь 2008 оны 4 дүгээр сарын 28-ны өдөр Монгол Улсын Компанийн тухай хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан бөгөөд Монголын Ипотекийн Корпораци ОССК ХХК ("МИК ОССК")-ийн 100 хувийн хөрөнгө оруулалттай охин компани байсан юм. Тус компани нь өмнө нь ТЗК А ХХК гэж нэрлэгддэг байсан бөгөөд 2015 оны 10 дугаар сарын 30-ны өдөр нэрээ өөрчилсөн. Компани нь 2015 оны 12 дугаар сарын 14-ний өдөр МИК ОССК-ийн Холдинг Компани болж, үндсэн үйл ажиллагаа нь хөрөнгө оруулалтын холдинг болж өөрчлөн байгуулсан.

Компанийн үндсэн үйл ажиллагаа явуулж буй газар, бүртгэлтэй хаяг нь Монгол улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Сүхбаатарын талбайн гудамж 11.

Компани нь нэг бүр нь 1,000 (2022 онд: 1,000) төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 20,709,320 (2022 онд: 20,709,320) ширхэг энгийн хувьцаанаас бүрдэх 20,709,320 мянган төгрөг (2022 онд: 20,709,320 мянган төгрөг)-ийн бүртгэлтэй хувьцаат хөрөнгөтэй.

Компани нь Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй, Монгол улсад үүсгэн байгуулагдсан, тус улсын нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулдаг хувьцаат компани юм. 2023 оны 12 дугаар сарын 31-нээрх Компанийн хувьцаа эзэмшигчдийн тухай Тодруулга 14-т тусгасан.

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2024 оны 3 дугаар сарын 18-ний өдрийн шийдвэрээр Компанийн санхүүгийн тайлангуудыг баталж, мэдээлэхийг зөвшөөрсөн.

2. Нягтлан бодох бүртгэлийн бодлогууд

2.1. Тайлан бэлтгэх үндэслэл

Компаний санхүүгийн тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөл ("НББОУСЗ")-өөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартууд ("СТОУС")-ын дагуу бэлтгэгдсэн болно.

Санхүүгийн тайлангууд нь түүхэн өртгийн зарчмаар бэлтгэгдсэн болно. Санхүүгийн тайлан дахь дүнгүүдийг тодруулгад өөрөөр зааснаас бусад тохиолдолд мянгачилан, Монгол Улсын мөнгөн тэмдэгт болох Монгол төгрөгөөр тайлагнасан.

Эдгээр санхүүгийн тайлангуудыг Компанийн бие даасан санхүүгийн тайлан хэлбэрээр бэлтгэсэн бөгөөд Компани болон түүний охин компаниудын нэгтгэсэн санхүүгийн тайланг тусад нь бэлтгэн гаргасан болно.

Компани болон түүний охин компаниудын нэгтгэсэн санхүүгийн тайлан нь олон нийтэд нээлттэй бөгөөд Компанийн бүртгэлтэй хаягаар эсвэл албан ёсны вэбсайт дээрээс харах боломжтой.

Санхүүгийн тайлангийн толилуулга

Компани нь санхүүгийн байдлын тайлангийн зүйлсийг хөрвөх чадварынх нь дарааллаар толилуулсан. Санхүүгийн байдлын тайлангийн өдрийн дараах 12 сарын дотор (богино хугацаанд) ба 12 сараас хойших хугацаанд (урт хугацаанд) хүлээн авах эсвэл төлөх төлбөрийн талаарх шинжилгээг тодруулга 16-д толилуулсан.

Хүлээн зөвшөөрсөн дүнгүүдийг цэвэршүүлэх хуулиар олгогдсон эрхтэй ба хөрөнгө, өр төлбөрийг зэрэг хүлээн зөвшөөрөх эсвэл цэвэр дүнгээр нь барагдуулах хандлагатай байгаа үед санхүүгийн хөрөнгө, санхүүгийн өр төлбөрүүдийг хооронд нь цэвэршүүлж, цэвэр дүнг санхүүгийн байдлын тайланд толилуулна. Нягтлан бодох бүртгэлийн стандарт эсвэл тайлбарт шаардаагүй эвсэл зөвшөөрөөгүй мөн Компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлогод тусгайлан толилуулаагүй тохиолдолд орлого ба зардлын дүнгүүдийг ашиг, алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайланд цэвэршүүлэхгүй.

2.2. Шинэ болон нэмэлт өөрчлөлт оруулсан стандартууд

Компани нь гаргасан санхүүгийн тайланд батлагдсан боловч хараахан хүчин төгөлдөр болоогүй шинэ стандарт, тайлбар, нэмэлт өөрчлөлтийг дагаж мөрдөөгүй. Доорх бусад нэмэлт өөрчлөлт, тайлбар нь 2023 онд анх удаа хэрэгжих боловч Компанийн санхүүгийн тайланд материаллаг нөлөө үзүүлэхгүй.

- СТОУС 17 *Даатгалын гэрээ*
- НББОУС 8-ын нэмэлт өөрчлөлт *Нягтлан бодох бүртгэлийн тооцооллын тодорхойлолт*
- НББОУС 1 ба СТОУС Практикийн бичиг баримт 2-ын нэмэлт өөрчлөлт *Нягтлан бодох бүртгэлийн бодлогыг толилуулах нь*
- НББОУС 12-ын нэмэлт өөрчлөлт *Нэг ажил гүйлгээнээс үүсэж буй хөрөнгө, өр төлбөрийн хойшлогдсон татвар*
- НББОУС 12-ын нэмэлт өөрчлөлт *Олон улсын татварын шинэчлэл – Хоёр багана загвар дүрэм*

2. Нягтлан бодох бүртгэлийн бодлогууд (үргэлжлэл)

2.3 Батлагдсан боловч хэрэгжиж эхлээгүй байгаа стандартууд

Компанийн санхүүгийн тайлангуудыг батлан гаргах өдрийн байдлаар батлагдсан боловч хэрэгжиж эхлээгүй байсан стандартуудын жагсаалтыг дор үзүүлэв. Компани энэхүү стандартууд болон нэмэлт өөрчлөлтүүдийг хүчин төгөлдөр хэрэгжиж эхлэх үеэс дагаж мөрдөнө.

- | | |
|--|---|
| • СТОУС 16-ийн нэмэлт өөрчлөлт | <i>Борлуулаад буцаан түрээсэлсэн хөрөнгийн түрээсийн өр төлбөр¹</i> |
| • НББОУС 1-ийн нэмэлт өөрчлөлт | <i>Богино хугацаат болон урт хугацаат өр төлбөрийн ангилал¹</i> |
| • НББОУС 1-ийн нэмэлт өөрчлөлт | <i>Гэрээгээр хүлээсэн үүрэгтэй эргэлтийн бус өр төлбөрүүд¹</i> |
| • НББОУС 7 ба СТОУС 7-ийн нэмэлт өөрчлөлт | <i>Нийлүүлэгчийн санхүүжилтийн зохицуулалт¹</i> |
| • НББОУС 21-ийн нэмэлт өөрчлөлт | <i>Солилооны хомсдол²</i> |
| • СТОУС 10 ба НББОУС 28-ын нэмэлт өөрчлөлт | <i>Хөрөнгө оруулагч ба түүний хараат компани, хамтарсан компанийн хооронд худалдсан эсхүл хандивласан хөрөнгө³</i> |

¹2024 оны 1 сараас эхлэн хүчин төгөлдөр үйлчилж эхэлнэ

²2025 оны 1 сараас эхлэн хүчин төгөлдөр үйлчилж эхэлнэ

³Хүчин төгөлдөр болох хугацааг тогтоогоогүй ч дагаж мөрдөх боломжтой

Энэхүү нэмэлт өөрчлөлт нь Компанийн санхүүгийн тайланд мэдэгдэхүйц нөлөө үзүүлэхгүй.

2.4. Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын хураангуй

Хүүний орлого болон зардлыг хүлээн зөвшөөрөх

Үр ашигт хүүний аргачлал

Хорогдуулсан өртгөөр бүртгэгдсэн санхүүгийн хэрэглүүр болон ашиг, алдагдлаас бодит үнэ цэнээр бүртгэгдсэн санхүүгийн хөрөнгийн хүүний орлого болон зардлыг үр ашигт хүүний аргыг ашиглан тодорхойлно. Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэгдэх хүүтэй санхүүгийн хөрөнгүүдийн хүүний орлогыг мөн үр ашигт хүүний аргыг ашиглан тодорхойлно. Мөн хорогдуулсан өртгөөр бүртгэгдсэн санхүүгийн өр төлбөрүүдийн хүүний зардлыг үр ашигт хүүний арга ашиглан тодорхойлно. Үр ашигт хүү гэдэг нь санхүүгийн хэрэглүүрийн ирээдүйд орж ирэх мөнгөн урсгалуудыг хугацааных нь туршид эсвэл тохиромжтой гэж үзсэн богино хугацаанд дансны үнэ эсвэл санхүүгийн хөрөнгийн хорогдуулсан өртөг хүртэл нь хямдруулах хүү юм.

Үр ашигт хүүг (цаашлаад, хөрөнгийн хорогдуулсан өртгийг) үр ашигт хүүний салшгүй хэсэг болох худалдан авалтын хөнгөлөлт, урамшуулал, шимтгэл болон зардлыг оролцуулан тооцдог. Компани нь зээлийн нийт хугацааны турш тогтмол өгөөж хүртэнэ гэсэн хамгийн сайн тооцооллыг илэрхийлэх өгөөжийн хувиар хүүний орлого болон зардлыг бүртгэдэг. Тиймээс өөр шатлалуудад тооцогдсон хүүгийн түвшнүүдийн нөлөөлөл болон бүтээгдэхүүний нийт хугацааны бусад шинж чанаруудыг (урьдчилж төлсөн төлбөр, нэмэгдүүлсэн хүү болон шимтгэлүүд) оролцуулан тооцдог.

Хэрэв тогтмол хүүтэй санхүүгийн хөрөнгө эсвэл өр төлбөрийн хүлээгдэж буй мөнгөн урсгал нь зээлийн эрсдэлээс бусад шалтгаанаар өөрчлөгдсөн бол ирээдүйд орж ирэх мөнгөн урсгалуудын өөрчлөлтийг анхны үр ашигт хүүгээр дискаунтчилан цаашлаад дансны үнийг тохируулна. Уг өөрчлөлт нь эерэг эсвэл сөрөг залруулгаар санхүүгийн байдлын тайланд тухайн санхүүгийн хөрөнгө эсвэл өр төлбөрийн дансны үнэд нөлөөлж үр ашигт хүүний аргаар тооцоолсон хүүний орлого/зардлыг нэмэгдүүлж эсвэл бууруулж болно. Энэхүү залруулга нь ашиг алдагдлын тайланд хүүний орлого болон зардлаар хорогдуулна.

Хураамж, шимтгэлийн орлого

Хураамж, шимтгэлийн орлого нь Компани охин компани болох МИК ОССК ХХК-ийн олон улсын хөрөнгийн зах зээлд гаргасан өрийн үнэт цаас цаастай холбоотойгоор Компанийн гаргасан санхүүгийн баталгааны шимтгэлийн орлогыг илэрхийлнэ (Тодруулга 3-ыг харна уу). Уг орлого нь санхүүгийн баталгааны хугацааны туршид шулуун шугамын аргаар хүлээн зөвшөөрөгддөг.

Удирдлагын зөвлөх үйлчилгээний орлого нь МИК ОССК ХХК-д менежментийн үйлчилгээ үзүүлсний төлөө олдог бөгөөд тухайн хугацаанд тооцсон нийт цагаар тооцож улирал бүр нэхэмжилдэг. Уг орлогыг улирал бүр хүлээн зөвшөөрнө.

Хураамж, шимтгэлийн зардал

Хураамжийн зардал нь арилжааны банканд тогтмол төлдөг үйлчилгээний шимтгэл хураамжийг илэрхийлдэг. Хураамжийн зардлыг бодитоор үйлчилгээ авсан тухай бүрд хүлээн зөвшөөрч бүртгэнэ. Тодорхой гүйцэтгэлийн хэмжээтэй холбогдох төлбөрийн бүрэлдэхүүн хэсгүүдийг гүйцэтгэл биелэгдсэн үед нь хүлээн зөвшөөрдөг.

2. Нягтлан бодох бүртгэлийн бодлогууд (үргэлжлэл)

2.4. Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын хураангуй (үргэлжлэл)

Санхүүгийн хэрэглүүр – анхны хүлээн зөвшөөрөлт ба дахин хэмжилт

Санхүүгийн хэрэглүүр гэдэг нь аж ахуйн нэгжийн санхүүгийн хөрөнгийг, өөр нэг байгууллагын санхүүгийн өр төлбөр эсвэл өмчийн хэрэглүүрийг бий болгодог аливаа гэрээ юм.

i) Санхүүгийн хөрөнгө

Анхны хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт

Компанийн санхүүгийн хөрөнгийг анхлан хүлээн зөвшөөрөхдөө хорогдуулсан өртгөөр, бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогоор (“БҮЦӨБДО”), ашиг алдагдлаас бодит үнэ цэнээр бүртгэгдэх санхүүгийн хөрөнгө (“ААБҮЦ”) гэж ангилна.

Анхлан хүлээн зөвшөөрөлтийн үед санхүүгийн хөрөнгийн ангилал нь тухайн гэрээний мөнгөн гүйлгээний шинж чанар ба Компанийн хөрөнгийг удирдах бизнесийн загвараас хамаарна. Компани нь санхүүгийн томоохон бүрэлдэхүүн хэсэггүй борлуулалтын авлагаас бусад санхүүгийн хөрөнгийг анхлан бодит үнэ цэнээр нь хэмжиж, ашиг, алдагдлаас бодит үнэ цэнээр бүртгэгдэх хөрөнгөөс бусад хөрөнгийн бодит үнэ дээр гүйлгээний зардлыг нэмсэн дүнгээр хэмжинэ.

Санхүүгийн хөрөнгийг хорогдуулсан өртгөөр эсвэл БҮЦӨБДО-р ангилахын тулд гэрээний мөнгөн гүйлгээ нь зөвхөн үндсэн төлбөрийн төлөлт болон үлдэгдэл төлбөрт ногдох хүүгийн төлөлтөөс бүрдсэн байх шаардлагатай. Энэ үнэлгээ нь ‘зөвхөн үндсэн болон хүүгийн төлбөр’ (“ЗҮХТ”) шалгуур гэж нэрлэгддэг ба хэрэглүүр тус бүрд хийгдэнэ.

Компанийн санхүүгийн хөрөнгийг удирдах бизнесийн загвар нь мөнгөн урсгалыг бий болгохын тулд санхүүгийн хөрөнгийг хэрхэн удирдахыг тодорхойлох учиртай. Бизнесийн загвар нь гэрээний мөнгөн урсгалыг цуглуулах, санхүүгийн хөрөнгийг борлуулж ашиг, алдагдал хүлээн зөвшөөрөх, эсвэл аль алиныг нь хэрэгжүүлэх замаар мөнгөн урсгал үүсэх эсэхийг тодорхойлно. Хөрөнгийн зах зээл дээр зохицуулалт, дүрэм журмаар тогтоосон хугацаанд (хэвийн нөхцөлтэй арилжаа) санхүүгийн хөрөнгийг нийлүүлэхийг шаарддаг худалдан авалт буюу борлуулалтыг борлуулалтын өдөр хүлээн зөвшөөрнө. Борлуулалтын өдөр нь тухайн хөрөнгийг худалдан авах эсвэл худалдах үүрэг авсан өдрийг илэрхийлнэ.

2023, 2022 оны 12-р сарын 31-ний байдлаар компанийн санхүүгийн хөрөнгө нь зөвхөн мөнгөн хөрөнгө болон банкн дахь харилцах хадгаламжаас бүрдэнэ (Тодруулга 7-г харна уу).

Үл хүлээн зөвшөөрөлт

Дараах тохиолдолд санхүүгийн хөрөнгийг (санхүүгийн хөрөнгийн хэсэг эсвэл хоорондоо төсөөтэй нэг бүлэг санхүүгийн хөрөнгийн хэсэг) үл хүлээн зөвшөөрнө. Үүнд:

- Тухайн хөрөнгөөс мөнгөн урсгал хүлээн авах эрхийн хугацаа дууссан,
- “Дамжуулан өнгөрөөх” хэлцлийн дагуу хүлээн авсан мөнгөө нийт дүнгээр нь удаан хугацаагаар саатуулалгүйгээр гуравдагч талд төлөх үүрэг хүлээсэн; эсвэл
 - Компани хөрөнгийн бүх эрсдэл ба өгөөжийг шилжүүлсэн, эсвэл
 - Компани тухайн хөрөнгөтэй холбоотой эрсдэл ба өгөөжийг шилжүүлээгүй болон хадгалж үлдээгүй боловч хөрөнгийн хяналтыг шилжүүлсэн.

Компани хөрөнгөөс мөнгө хүлээн авах эрхээ шилжүүлсэн эсвэл “дамжуулан өнгөрөөх” хэлцэл хийсэн боловч хөрөнгөтэй холбоотой ихэнх эрсдэл, өгөөж болон хяналтыг шилжүүлээгүй тохиолдолд хөрөнгийг Компанийн уг хөрөнгөд үргэлжлүүлэн оролцоор байх хэмжээгээр нь хүлээн зөвшөөрнө. Энэ тохиолдолд Компани холбогдох өр төлбөрийг мөн хүлээн зөвшөөрнө. Шилжүүлсэн хөрөнгө ба холбогдох өр төлбөр Компанийн хадгалж үлдсэн эрх, үүргийг тусган харуулсан сууриар хэмжинэ. Энэхүү үргэлжилсэн оролцоо нь шилжүүлсэн хөрөнгийн баталгаа хэлбэртэй байвал оролцоог тус хөрөнгийн анхны бүртгэлийн дүн ба Компанийн төлөх шаардлагатай болох хамгийн их дүнгийн аль багаар хэмжинэ.

Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралт

СТОУС 9-ийн дагуу хүлээгдэж буй зээлийн алдагдлыг тооцоолох нь санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралтад мэдэгдэхүйц нөлөө үзүүлээгүй, учир нь компанийн банкн дахь харилцах хадгаламжаас бүрдэх санхүүгийн хөрөнгө нь материаллаг биш байсан.

2. Нягтлан бодох бүртгэлийн бодлогууд (үргэлжлэл)

2.4. Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын хураангуй (үргэлжлэл)

ii) Санхүүгийн өр төлбөр

Анхны хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт

Санхүүгийн өр төлбөрүүд буюу зээл, зээлээр авсан эх үүсвэр, өглөг, хеджийн хэрэглүүрээр ашиглах үүсмэл санхүүгийн хэрэглүүр зэргийг анхлан хүлээн зөвшөөрөхдөө бодит үнэ цэнийн өөрчлөлтийг ашиг алдагдлаар бүртгэгдэх санхүүгийн өр төлбөрөөр бүртгэнэ.

Бүх санхүүгийн өр төлбөр буюу зээл, зээлээр авсан эх үүсвэр, өглөг зэргийг тэдгээртэй хамааралтай ажил гүйлгээний зардлуудыг оруулан анх бодит үнэ цэнээр хүлээн зөвшөөрнө.

2023, 2022 оны 12-р сарын 31-ний байдлаар Компанийн санхүүгийн өр төлбөр нь бусад өр төлбөр болон нөөц сангаас бүрдэнэ (Тодруулга 12, 13-ыг харна уу).

Үл хүлээн зөвшөөрөлт

Санхүүгийн өр төлбөрийг төлөхөөс чөлөөлөгдсөн, өр төлбөр цуцлагдсан эсвэл хугацаа нь дууссан бол үл хүлээн зөвшөөрдөг. Хэрэв одоо байгаа санхүүгийн өр төлбөрийн зээлдүүлэгч нь хэвээрээ боловч ялгаатай нөхцөлтэй зээлийн гэрээгээр сольсон эсвэл одоо байгаа зээлийн нөхцөл эрс өөрчлөгдсөн бол эдгээр өөрчлөлт шинэчлэлтийг анхны санхүүгийн өр төлбөрийн үл хүлээн зөвшөөрөлт ба шинэ өр төлбөрийн хүлээн зөвшөөрөлт гэж үзнэ. Анхны санхүүгийн өр төлбөрийн бүртгэлийн дүн ба төлсөн дүн хоёрын зөрүүг ашиг, алдагдлын тайланд хүлээнэ.

Бодит үнэ цэнийн тодорхойлолт

Бодит үнэ цэнэ гэдэг нь хэмжилт хийсэн өдрийн зах зээлд оролцогчдын хооронд хийсэн дэс дараалалтай гүйлгээний үр дүнд борлуулснаас орж ирэх мөнгөн дүн болон өр төлбөрт шилжүүлсэн мөнгөн дүн юм. Бодит үнэ цэнийн хэмжилт нь дараах зах зээл дээр хөрөнгийг борлуулсан эсвэл өр төлбөрийг шилжүүлсэн гүйлгээний дүнгээр тодорхойлно:

- Хөрөнгө ба өр төлбөрийн үндсэн зах зээлд, эсвэл
- Үндсэн зах зээл байхгүй тохиолдолд, хөрөнгө ба өр төлбөрийн хувьд хамгийн ашигтай зах зээлд

Үндсэн болон хамгийн ашигтай зах зээл нь Компанийн хувьд оролцож болохуйц зах зээлүүд байх ёстой.

Хөрөнгө ба өр төлбөрийн бодит үнэ цэнийг хэмжихэд ашигласан үнэ нь зах зээлд оролцогчид нь хөрөнгө ба өр төлбөрийн эдийн засгийн хамгийн өндөр үр өгөөжийг хүртэнэ гэсэн төсөөлөл дээр үндэслэдэг.

Санхүүгийн бус хөрөнгийн бодит үнэ цэнийн хэмжилтийг, тухайн зах зээлд оролцогч тал нь хөрөнгийг ашигласнаар хамгийн өндөр эдийн засгийн үр өгөөжийг хүртэж чадаж байх эсвэл уг хөрөнгийг борлуулснаар худалдан авсан талд уг хөрөнгийг ашигласнаар хамгийн өндөр эдийн засгийн үр өгөөжийг өгч байх, нөхцөлд тооцно.

Компани нь бодит үнэ цэнэ тооцоход шаардлагатай мэдээллүүд нь хангалттай олдоцтой үед үнэлгээний техникүүдийг хэрэглэх нь тохиромжтой байдаг ба ажиглагдахуйц өгөгдлийн хэрэглээг нэмэгдүүлж, үл ажиглагдахуйц өгөгдлийн хэрэглээг хамгийн бага түвшинд байлгадаг.

Бодит үнэ цэнээрээ хэмжигдэж, санхүүгийн тайланд тайлагнаж байгаа бүх хөрөнгө, өр төлбөрийн бодит үнэ цэнийг тодорхойлох, толилуулахдаа дараах түвшнийг хэрэглэдэг. Үүнд:

Түвшин 1- Үнэлгээнд ашиглагдсан өгөгдлүүд нь хэмжилтийн өдрөөрх бирж дээр бүртгэлтэй ижил төсөөтэй хөрөнгө болон өр төлбөрийн (залруулаагүй) идэвхтэй зах зээл дээрх үнэ юм.

Түвшин 2- Үнэлгээнд ашигласан өгөгдлүүдийг санхүүгийн хэрэглүүрийн дуусах хугацааны туршид боломжтой байх зах зээлийн бүх өгөгдлүүдээс шууд болон шууд бусаар үнэлгээнд ашигласан өгөгдлүүд юм

Түвшин 3- Хэмжилтийн хувьд бүхэлдээ чухал ач холбогдол бүхий нэг болон түүнээс дээш ажиглагдахуйц бус өгөгдлүүд багтана.

Тайлант хугацааны эцэс бүрд Компани нь санхүүгийн тайландаа тайлагнасан хөрөнгө, өр төлбөрийн хувьд түвшин хооронд хөдөлгөөн гарсан эсэхийг дахин нягталж үздэг.

Санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийн шинжилгээ болон бусад шаардлагатай мэдээллийг Тодруулга 19-д тусгасан.

Банкан дахь харилцах, хадгаламж

Санхүүгийн байдлын тайланд тусгасан бэлэн мөнгө ба банкан дахь харилцах, хадгаламж нь бэлэн мөнгө болон банкуудад байршуулсан харилцах болон хадгаламж зэрэг үнэ цэнийн буралтын эрсдэл маш бага хөрөнгүүд хамаарна.

2. Нягтлан бодох бүртгэлийн бодлогууд (үргэлжлэл)

2.4. Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын хураангуй (үргэлжлэл)

Банкан дахь харилцах, хадгаламж (үргэлжлэл)

Мөнгөн гүйлгээний тайланд зааснаар мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгөд бэлэн мөнгө, банкан дахь хязгаарлагдаагүй, харилцах ба хугацаагүй эсвэл 3 сар хүртэлх анхны дуусгавар хугацаатай хадгаламжууд орно.

Үндсэн хөрөнгө

Бүх үндсэн хөрөнгийг анхны өртгөөр нь бүртгэдэг. Дараагийн тайлант хугацаанд гарсан зардлыг тухайн зардалтай холбогдсон ирээдүйн эдийн засгийн үр өгөөжийг Компани хүртэх магадлалтай ба өртгийг нь найдвартайгаар хэмжих боломжтой тохиолдолд л хөрөнгийн бүртгэлийн дүн дээр нэмж эсвэл зохистой бол тусдаа хөрөнгөөр хүлээн зөвшөөрдөг. Аливаа сольсон хэсгийн бүртгэлийн дүнг үл хүлээн зөвшөөрнө. Бусад бүх урсгал засварыг тэдгээрийн гарсан тайлангийн хугацааны ашиг, алдагдал болон бусад дэлгэрэнгүй орлогын тайланд хүлээн зөвшөөрдөг.

Хүлээн зөвшөөрсний дараах үед үндсэн хөрөнгийг хуримтлагдсан элэгдэл ба хуримтлагдсан үнэ цэнийн бууралтын алдагдлыг хассан өртгөөр илэрхийлдэг.

Хөрөнгө тус бүрийн өртгийг үлдэх өртөг хүртэл нь, ойролцоолон тооцоолсон дараах ашиглалтын хугацааны туршид, шулуун шугамын аргаар элэгдүүлнэ.

Тавилга, эд хогшил	10 жил
Компьютер	2 жил

Үндсэн хөрөнгийн үлдэх өртөг, ашиглалтын хугацаа, элэгдлийн арга нь өмнө хийгдсэн тооцоолол ба үндсэн хөрөнгөд агуулагдаж буй ирээдүйн эдийн засгийн үр ашгийн хүлээгдэж буй хэрэглээний хэв загварт нийцэж байгаа гэдгийг баталгаажуулах үүднээс үндсэн хөрөнгийн үлдэх өртөг, ашиглалтын хугацаа, элэгдлийн аргыг тайлант жилийн эцэс бүрт хянаж үздэг.

Үндсэн хөрөнгө ба түүний томоохон хэсгүүдийг худалдан борлуулах үед эсвэл түүний ашиглалт, борлуулалтаас ирээдүйд эдийн засгийн үр ашиг хүлээгдэхгүй болсон үед данснаас хасна. Үүнтэй холбоотойгоор үүссэн аливаа нэг олз, гарзыг (хөрөнгө борлуулалтын цэвэр орлого ба бүртгэлийн дүн хоёрын зөрүүгээр тооцно) тухайн тайлант жилийн ашиг, алдагдлын тайланд тусгана.

Биет бус хөрөнгө

Компанийн биет бус хөрөнгөд компьютерын программ хангамжийн эрх багтана.

Зөвхөн биет бус хөрөнгийн өртгийг зохистойгоор хэмжиж болох ба хүлээгдэж буй эдийн засгийн ирээдүйн өгөөж нь Компанид орж ирэх нь магадлалтай болсон үед л биет бус хөрөнгийг хүлээн зөвшөөрнө. Тусад нь авсан биет бус хөрөнгийг анх хүлээн зөвшөөрөхдөө өртгөөр нь бүртгэдэг. Анх хүлээн зөвшөөрснөөс хойших тайлант үед, биет бус хөрөнгийг хуримтлагдсан хорогдуулалт болон үнэ цэн бууралтын алдагдлыг хассанаар бүртгэнэ.

Биет бус хөрөнгийн ашиглалтын хугацаа нь тодорхой эсвэл тодорхой бус эсэхийг үнэлнэ. Ашиглалтын тодорхой хугацаатай биет бус хөрөнгийг эдийн засгийн үр ашигтай хугацааны туршид нь хорогдуулна. Ашиглалтын тодорхой хугацаатай биет бус хөрөнгийн хорогдуулах хугацаа болон аргыг хамгийн багадаа тайлант жил бүрийн эцэст хянаж үздэг. Хүлээгдэж буй ашиглалтын хугацаа эсвэл хүлээгдэж буй ирээдүйн үр өгөөжийн хэв загварт орсон өөрчлөлтийг хорогдуулалтын хугацаа эсвэл аргын аль тохиромжтойг нь өөрчлөх замаар бүртгэлд тусгах ба уг өөрчлөлтийг нягтлан бодох бүртгэлийн тооцооллын өөрчлөлт гэж үзнэ.

Хязгаарлагдмал хугацаатай биет бус хөрөнгийн хорогдуулалтын зардлыг ашиг, алдагдлын тайланд биет бус хөрөнгийн үүрэгтэй нь нийцсэн зардлын бүлэгт хүлээн зөвшөөрнө. Биет бус хөрөнгийн өртгийг 2 жилийн ашиглалтын хугацааны туршид, шулуун шугамын аргыг ашиглан, үлдэх өртөг хүртэл нь хорогдуулна.

Охин компани дахь хөрөнгө оруулалт

Охин компани гэдэг нь Компаний шууд болон шууд бусаар хянадаг байгууллага юм. Компани нь хөрөнгө оруулалт хийсний үндсэн дээр хувьсах өгөөж авч, эрхээ эдэлж, хөрөнгө оруулалтыг удирдах эрх мэдлээрээ дамжуулан тэдгээр өгөөжид нөлөөлөх чадвартай (өөрөөр хэлбэл, Компанид үйл ажиллагааг чиглүүлэх одоогийн боломжийг олгодог одоо байгаа эрхүүд) бол хяналтыг бий болгодог.

Компани нь шууд болон шууд бусаар олонхийн саналын буюу түүнтэй адилтгах эрхтэй хөрөнгө оруулалтын объектын эрх мэдэлтэй эсэхээ үнэлэхдээ холбогдох бүх баримт, нөхцөл байдлыг харгалзан үздэг. Үүнд:

- (а) хөрөнгө оруулалтын объектын бусад санал эзэмшигчидтэй байгуулсан гэрээний зохицуулалт;
- (б) бусад гэрээний зохицуулалтаас үүсэх эрх; ба
- (в) компанийн саналын эрх болон боломжит саналын эрх.

2. Нягтлан бодох бүртгэлийн бодлогууд (үргэлжлэл)

2.4. Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын хураангуй (үргэлжлэл)

Охин компани дахь хөрөнгө оруулалт (үргэлжлэл)

Охин компаниудын үр дүнг Компанийн ашиг, алдагдлын тайланд хүлээн авсан болон авах ногдол ашгийн хэмжээгээр тусгана.

Компанийн санхүүгийн тайланд охин компанид оруулсан хөрөнгө оруулалтыг үнэ цэнийн бууралтын алдагдлыг хассан өртгөөр тусгасан болно. Ийм хөрөнгө оруулалтыг татан буулгах үед зарж борлуулсны цэвэр орлого ба тэдгээрийн дансны үнийн зөрүүг ашиг, алдагдалд оруулна.

Санхүүгийн бус хөрөнгийн үнэ цэнийн бууралт

Хөрөнгө нь үнэ цэнийн бууралтад орсон байж болох шинж тэмдэг байгаа эсэхийг Компани тайлант хугацаа тутамд шалгаж үздэг. Хэрэв тийм шинж тэмдэг илэрсэн эсвэл жилд нэг удаа хийдэг хөрөнгийн үнэ цэнийн бууралтын тестийг хийх шаардлагатай үед Компани нь хөрөнгөөс цуглуулан авах боломжтой дүнг тооцоолно. Цуглуулан авах дүн нь хөрөнгийн эсвэл бэлэн мөнгө бий болгогч нэгжийн бодит үнэ цэн (борлуулалтын зардлыг хасаж тооцсон) ба ашиглалтын үнэ цэн хоёрын аль өндөр нь байна. Хөрөнгийн эсвэл бэлэн мөнгө бий болгогч нэгжийн дансны дүн нь цуглуулан авах дүнгээс илүү байгаа үед хөрөнгийг үнэ цэнийн бууралтад орсон гэж үзэн цуглуулан авах дүн хүртэл нь бууруулж бүртгэнэ. Ашиглалтын үнийг үнэлэхдээ, тооцоолсон ирээдүйн мөнгөн урсгалыг мөнгөний цаг хугацааны үнэ цэн ба хөрөнгөд харгалзах эрсдэлүүдийн талаарх өнөөгийн зах зээлийн үнэлгээнүүдийг тусгасан татварын өмнөх хөнгөлөлтийн хувь хэмжээгээр бууруулан өнөөгийн үнэ цэнийг олно. Борлуулалтын зардлыг хассаны дараах бодит үнэ цэнийг тодорхойлохдоо тохиромжтой үнэлгээний загварыг ашиглан тооцоолно. Үнэлгээний үржүүлэгч, нийтэд хувьцаагаа зардаг охин компанийн хөрөнгийн бирж дээрх хувьцааны үнэ эсвэл бодит үнэ цэнийн бусад үзүүлэлтүүдээр эдгээр тооцооллыг хэмжиж болно.

Гүүдвиллээс бусад хөрөнгүүд дээр, тайлагналын өдөр бүр өмнө хүлээн зөвшөөрсөн үнэ цэнийн бууралтын алдагдал арилсан эсвэл буурсан эсэх талаар ямар нэгэн шинж тэмдэг байгаа эсэх талаар үнэлгээг хийдэг. Хэрэв тийм шинж тэмдэг илэрвэл Компани нь тухайн хөрөнгийн эсвэл бэлэн мөнгө бий болгогч нэгжийн нөхөн төлөгдөх дүнг ойролцоогоор тооцож үзнэ. Хамгийн сүүлд үнэ цэнийн бууралтыг хүлээн зөвшөөрснөөс хойш хөрөнгийн цуглуулан авах дүнг тодорхойлоход ашигласан тооцооллуудад өөрчлөлт гарсан тохиолдолд л өмнө хүлээн зөвшөөрсөн үнэ цэнийн бууралтыг буцаана. Буцаалт нь хязгаартай байх ба ингэснээр хөрөнгийн бүртгэлийн дүн нь цуглуулан авах дүн ба өмнөх жилүүдэд хөрөнгийн үнэ цэнийн алдагдлыг хүлээн зөвшөөрөөгүй байсан бол байх ёстой байсан бүртгэлийн цэвэр дүнгээс (элэгдлийг хассан цэвэр дүнгээс) хэтрэхгүй байна. Ийм буцаалтуудыг ашиг, алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайланд хүлээн зөвшөөрнө.

Татвар

(i) Тайлант хугацааны орлогын албан татвар

Одоогийн болон өмнөх тайлант хугацааны өнөөгийн албан татварын хөрөнгө ба өр төлбөрийг татварын байгууллагаас буцаан авахаар хүлээж байгаа эсвэл татварын байгууллагад төлөх дүнгээр хэмжинэ. Энэ дүнг тооцоолоход хэрэглэсэн татварын хувь хэмжээ, татварын хуулиуд нь санхүүгийн байдлын тайлангийн өдрийн байдлаар хүчин төгөлдөр үйлчилж байсан.

(ii) Хойшлуулсан татвар

Хойшлуулсан орлогын албан татварыг тайлагналын өдрийн байдлаарх хөрөнгө, өр төлбөрийн татварын суурь, тэдгээрийн санхүүгийн бүртгэлийн дүн хоёрын хооронд түр зөрүүний дүнгээс тайлан тэнцлийн аргыг хэрэглэн тооцдог. Дараахаас бусад бүх түр зөрүүнүүд дээр хойшлуулсан орлогын албан татварын өр төлбөрийг хүлээн зөвшөөрнө. Үүнд:

- Хэрэв хойшлуулсан орлогын албан татварын хөрөнгө нь бизнесийн нэгдлийн үеийн бус гүйлгээнээс үүссэн ба гүйлгээ хийгдэх үед нягтлан бодох бүртгэлийн ашиг ба татвар ногдох ашгийн аль алинд нөлөө үзүүлэхгүй хөрөнгө, өр төлбөрүүдийн анхны хүлээн зөвшөөрөлтөөс үүссэн бол;
- Охин компанид оруулсан хөрөнгө оруулалт, хамтарсан компани дахь ашиг сонирхолтой холбоотой татвар ногдох түр зөрүүнүүдийн хувьд, үүссэн түр зөрүү нь ойрын ирээдүйд арилах ба түр зөрүүг ашиглаж болох татвар ногдох ашиг олох магадлал байгаа бол.

Хойшлуулсан орлогын албан татварын хөрөнгийн бүртгэлийн дүнг санхүүгийн байдлын тайлангийн өдөр бүр хянаж үздэг ба энэхүү хөрөнгийг бүхэлд нь эсвэл хэсэгчлэн ашиглахад хангалттай хэмжээний татвар ногдох орлого орж ирэх магадлал буурах үед уг бүртгэлийн дүнг бууруулна. Үл хүлээн зөвшөөрсөн хойшлуулсан орлогын албан татварын хөрөнгийг санхүүгийн байдлын тайлангийн өдөр бүр дахин үнэлж үздэг ба хойшлуулсан орлогын албан татварын хөрөнгийг ашиглахыг зөвшөөрсөн татвар ногдох орлого ирээдүйд орж ирэх магадлалтай болсон үед хүлээн зөвшөөрнө.

2. Нягтлан бодох бүртгэлийн бодлогууд (үргэлжлэл)

2.4. Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын хураангуй (үргэлжлэл)

Татвар (үргэлжлэл)

(ii) Хойшлуулсан татвар (үргэлжлэл)

Хөрөнгийг олж авах эсвэл өр төлбөрийг барагдуулах тэр тайлант хугацаанд хэрэглэгдэнэ гэж хүлээж байгаа (тайлант жилийн эцсийн өдрийн байдлаар хүчин төгөлдөр үйлчилж байсан татварын хувь хэмжээ, татварын хуулиуд дээр үндэслэн) татварын хувь хэмжээгээр хойшлуулсан орлогын албан татварын хөрөнгө, өр төлбөрийг хэмжинэ.

Өөрийн хөрөнгөнд шууд хүлээн зөвшөөрсөн зүйлүүдтэй холбоотой тайлант жилийн болон хойшлуулсан татваруудыг мөн өөрийн хөрөнгөнд хүлээн зөвшөөрөх ба ашиг, алдагдлын тайланд хүлээн зөвшөөрөхгүй.

Нэг татвар төлөгч, нэг татварын байгууллагад хамаарах хойшлуулсан орлогын албан татварын хөрөнгө ба өр төлбөрийг хооронд нь цэвэршүүлэн тайлагнах хуулиар олгогдсон эрхтэй бол хойшлуулсан орлогын албан татварын хөрөнгө ба өр төлбөрийг хооронд нь цэвэршүүлэн тайлагнаж болно.

Нөөц

Компанийн өнгөрсөн үйл явдлын үр дүнд үүссэн өнөөгийн үүрэг (хуулийн эсвэл ёс зүйн) байгаа энэхүү үүргээ биелүүлэхэд эдийн засгийн өгөөж агуулсан баялгийг зарцуулах нь тодорхой болсон ба үүргийн дүнг бодитойгоор ойролцоолон тооцоолох боломжтой үед нөөцийг хүлээн зөвшөөрнө. Аливаа нэг нөөцтэй холбоотой зардлыг ашиг, алдагдлаар аливаа нөхөн төлбөрийг хассан цэвэр дүнгээр нь толилуулна.

Санхүүгийн баталгаа

Санхүүгийн баталгааг хүлээн авсан урамшуулал болох бодит үнэ цэнээр нь санхүүгийн тайланд (Нөөцүүд дотор) хүлээн зөвшөөрнө. Анх хүлээн зөвшөөрөгдсөний дараа баталгаа тус бүрээр компанийн өр төлбөрийг орлогын тайланд хүлээн зөвшөөрсөн хуримтлагдсан хорогдлыг хасаж тооцсон дүнгээс хамгийн их буюу эрсдэлийн сангийн дүнгээр хэмжинэ.

Хүлээн авсан шимтгэлийг орлогын тайланд шимтгэл, шимтгэлийн орлогод баталгааны хугацаанд шулуун шугамын аргаар хүлээн зөвшөөрнө.

Компанийн гаргасан санхүүгийн баталгааны талаарх дэлгэрэнгүй мэдээллийг Тодруулга 13-т харуулсан болно.

Эздийн өмч

(i) Энгийн хувьцаа болон нэмж төлөгдсөн капитал

Энгийн хувьцааг өөрийн хөрөнгөд ангилсан. Шинэ хувьцаа гаргахтай шууд холбоотой өсөн нэмэгдэх зардлуудыг хувьцаа гаргасан орлогоос татварыг хассаны дараах байдлаар өөрийн хөрөнгийг хорогдуулах байдлаар харуулна. Энгийн хувьцааг нэрлэсэн үнээс дээш үнээр борлуулсан тохиолдолд нэрлэсэн үнээс дээших хэсгийг нэмж төлөгдсөн капиталгаар бүртгэнэ.

(ii) Хуримтлагдсан ашиг

Хуримтлагдсан ашиг нь зарласан ногдол ашгаар буурдаг хуримтлагдсан ашиг, алдагдлыг илэрхийлнэ.

Холбоотой талын ажил гүйлгээ

Холбоотой талууд гэдэгт Банктай дараах байдлаар холбогдсон аж ахуй нэгж болон хувь хүн орно. Үүнд: Компанитай дараах байдлаар холбогдсон хувь хүн эсвэл тухайн хувь хүний ойрын төрөл садан:

- Компанид дангаараа эсвэл хамтран хяналт тогтоосон;
- Компанид томоохон нөлөөлөлтэй эсвэл
- Компанийн эсвэл Компанийн толгой компанийн гол удирдах албан тушаалтнуудын нэг.

Дараах нөхцөлүүдийн аль нэг нь биелсэн тохиолдолд аж ахуй нэгж нь Компанид хамааралтай болно. Үүнд:

- Аж ахуйн нэгж болон Компани нь нэг ижил группийн гишүүд байх (толгой компани, охин компани болон нөгөө охин компани тус бүр нь бусадтайгаа холбоотой).
- Нэг аж ахуйн нэгж нь нөгөө аж ахуйн нэгжийн хараат компани эсвэл хамтын хэлэлцээрт компани (эсвэл нөгөө аж ахуйн нэгж нь гишүүн болох Компанийн хараат компани эсвэл хамтарсан хэлэлцээрт компани).
- Аль аль аж ахуйн нэгж нь нэг ижил гуравдагч этгээдийн хамтарсан хэлэлцээрт компаниуд.
- Нэг аж ахуйн нэгж нь гуравдагч аж ахуйн нэгжийн хамтарсан хэлэлцээрт компани бөгөөд нөгөө этгээд нь гуравдагч аж ахуй нэгжийн хараат компани.
- Аж ахуйн нэгж нь Компанийн эсвэл Компанитай холбоотой аж ахуйн нэгжийн ажиллагсдыг урамшуулах зорилгоор ажил эрхлэлтийн дараах тэтгэмж олгодог. Хэрвээ Компани нь уг хөтөлбөрийг хэрэгжүүлдэг бол дэмжлэг хүртэж буй ажиллагсад нь мөн Компанитай холбоотой тал болно.

2. Нягтлан бодох бүртгэлийн бодлогууд (үргэлжлэл)

2.4. Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын хураангуй (үргэлжлэл)

Холбоотой талын ажил гүйлгээ (үргэлжлэл)

- Аж ахуйн нэгжийг Компанид дангаараа эсвэл хамтран хяналт тогтоосон хувь хүн дангаараа эсвэл хамтран хяналт тогтоодог.
- Компанид дангаараа эсвэл хамтран хяналт тогтоосон хувь хүн нь аж ахуйн нэгжид томоохон нөлөөлөлтэй эсвэл уг аж ахуйн нэгжийн (эсвэл аж ахуйн нэгжийн толгой компанийн) гол удирдах албан тушаалтнуудын нэг.
- Аж ахуйн нэгж нь эсвэл группийн аль нэг гишүүн нь Компани эсвэл Компанийн толгой компанид гол удирдах албан тушаалтай.

Холбоотой талуудтай хийсэн материаллаг бүх гүйлгээ болон дансны үлдэгдлийн мэдээллүүдийг санхүүгийн тайланд хавсаргасан бөгөөд Тодруулга 17-д задаргааг толилуулсан.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн гол үнэлэмж, тооцоолол болон төсөөллүүд

Компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлогыг хэрэглэх явцаа удирдлага нь санхүүгийн тайлангуудад хүлээн зөвшөөрсөн дүнгүүдийг тодорхойлохдоо дараах үнэлэмж, ойролцоолсон тооцооллуудыг хэрэглэдэг. Хамгийн гол үнэлэмж, тооцооллуудыг дор үзүүлэв:

Охин компанид оруулсан хөрөнгө оруулалтын үнэ цэнийн бууралт

Компани охин компаниудад оруулсан хөрөнгө оруулалтынхаа үнэ цэнийн бууралтыг тухайн хөрөнгө оруулалтын дансны үнийг нөхөх боломжгүй болохыг харуулсан үйл явдал эсвэл нөхцөл байдлын өөрчлөлт бүрд үнэлдэг. Компанийн охин компаниудын хувьцааны үнэ ханшийн бууралтыг хассан өртгөөр толилуулдаг. Удирдлага нь охин компаниудад оруулсан хөрөнгө оруулалтын үнэ цэнийн бууралтын үнэлгээг жил бүр хийдэг. 2023, 2022 оны 12-р сарын 31-ний байдлаар хийсэн үнэлгээгээр охин компанид оруулсан хөрөнгө оруулалтын дансны үнэ нөхөгдөх хэмжээнээс хэтрээгүй бөгөөд удирдлагын дүгнэлтээр охин компанид оруулсан хөрөнгө оруулалтын үнэ цэнэ буураагүй байна.

Охин компанид оруулсан хөрөнгө оруулалтын талаар Тодруулга 11-д дэлгэрэнгүй тайлбарласан болно.

3. Хүүний орлого

	2023	2022
	мян.төг	мян.төг
<i>Хугацааны туршид хүлээн зөвшөөрөх шимтгэл, хураамжийн орлого</i>		
Санхүүгийн баталгааны шимтгэлийн орлого (Тод.17)	2,219,170	2,659,091
Удирдлагын зөвлөх үйлчилгээний орлого (Тод.17)	800,832	396,200
	<u>3,020,002</u>	<u>3,055,291</u>

Шимтгэл, хураамжийн орлогод 2021 оны 2-р сард Компани охин компани болох МИК ОССК ХХК-ийн олон улсын хөрөнгийн зах зээлд гаргасан өрийн үнэт цаастай холбоотойгоор Компанийн гаргасан санхүүгийн баталгааны шимтгэлийн орлого орсон (Тодруулга 13-ыг харна уу). Удирдлагын зөвлөх үйлчилгээний орлого нь МИК ОССК ХХК-д үзүүлсэн менежментийн үйлчилгээний төлбөр юм. (Тодруулга 17-г харна уу).

4. Хүлээгдэж буй үнэ цэнийн бууралтын алдагдлын зардал

	2023	2022
	мян.төг	мян.төг
Санхүүгийн баталгаа (Тод.13)	575,443	–
Бэлэн мөнгө ба банкн дахь харилцах, хадгаламж (Тод.7)	(887)	863
	<u>574,556</u>	<u>863</u>

МИК ХОЛДИНГ ХК

Санхүүгийн тайлангийн тодруулгууд – 2023 оны 12 дугаар сарын 31

5. Үйл ажиллагааны зардал

	2023	2022
	мян.төг	мян.төг
Боловсон хүчний зардлууд*	911,395	1,606,267
Мэргэжлийн үйлчилгээний төлбөр	96,767	38,544
Элэгдлийн зардал (Тодруулга 9)	26,187	31,733
Хорогдуулалтын зардал (Тодруулга 10)	14,262	8,903
Томилолтын зардал	5,455	–
Зар сурталчилгааны зардал	–	9,208
Үйл ажиллагааны бусад зардал	36,579	46,870
	<u>1,090,645</u>	<u>1,741,525</u>
* Боловсон хүчний зардал		
Цалин, шагнал, урамшуулал	794,665	1,393,073
Эрүүл мэнд, нийгмийн даатгалын шимтгэл	100,150	173,227
Ажилчдын сургалт	12,657	15,677
Бусад	3,923	24,290
	<u>911,395</u>	<u>1,606,267</u>

6. Орлогын албан татвар

6.1. Орлогын албан татварын зардал

2023 оны 12 дугаар сарын 31-нээр дуусгавар болсон орлогын албан татварын зардлын бүрэлдэхүүнд:

	2023	2022
	мян.төг	мян.төг
Тайлант жилийн татвар		
Тайлант жилийн орлогын албан татвар	<u>211,909</u>	<u>143,687</u>

Компани нь санхүүгийн тайланд орлогын дүнг орлогын татварыг хуульд заасан чөлөөлөгдөх эсвэл үл чөлөөлөгдөх зүйлүүдээр залруулсан дүнг үндэслэн орлогын албан татварыг тооцдог. Компани нь 6 тэрбум (2022 онд 6 тэрбум) төгрөг хүртэлх ашгаас 10% (2022 онд 10%)-ийн, 6 тэрбумаас (2022 онд 6 тэрбум) дээш төгрөгийн ашгаас 25% (2022 онд 25%)-ийн орлогын албан татвар төлдөг.

Татварын өмнөх ашгаас хуулиар тогтоосон хувь хэмжээгээр тооцож гаргасан орлогын татварын зардлыг компанид хүчин төгөлдөр үйлчлэх орлогын татварын хувь хэмжээгээр тооцож гаргасан орлогын татварын зардалд 12 дугаар сарын 31-нээр хэрхэн тохируулсныг дараах байдлаар үзүүлэв. Үүнд:

	2023	2022
	мян.төг	мян.төг
Татварын өмнөх ашиг	<u>1,520,566</u>	<u>1,399,042</u>
Татварын хувь хэмжээ болох 10%-иар тооцсон орлогын татварын зардал (2022 онд: 10%)	152,057	139,904
Татварын зорилгоор хасагдахгүй зардлын нөлөө	60,763	3,783
Татвараас чөлөөлөгдөх орлогын нөлөө	(88)	–
Бусад	(823)	–
Тайлант жилийн татварын зардал	<u>211,909</u>	<u>143,687</u>

6.2. Орлогын албан татварын өр/(урьдчилгаа)

	2023	2022
	мян.төг	мян.төг
1 дүгээр сарын 1-нээр	49,121	(1,305)
Бусад татварын авлагаар дахин ангилсан	(7,667)	–
Тайлант жилд хүлээн зөвшөөрсөн (Тод.6.1)	211,909	143,687
Төлсөн орлогын албан татвар	(145,748)	(93,261)
Бусдад суутгуулсан орлогын албан татвар	(16,450)	–
12 дугаар сарын 31-нээр	<u>91,165</u>	<u>49,121</u>

МИК ХОЛДИНГ ХК

Санхүүгийн тайлангийн тодруулгууд – 2023 оны 12 дугаар сарын 31

7. Бэлэн мөнгө ба банканд дахь харилцах, хадгаламж

	2023 мян.төг	2022 мян.төг
Бэлэн мөнгө	2,301	7,547
Банканд дахь харилцах данс	1,989,706	5,145
Банканд дахь хугацаатай хадгаламж	–	2,512,918
Дансны үнэ	1,992,007	2,525,610
Үнэ цэнийн бууралтын сан	(54)	(941)
Цэвэр дансны үнэ	1,991,953	2,524,669

Бүх банканд дахь данс нь Монгол улсад үйл ажиллагаагаа явуулдаг арилжааны банканд байршина. Мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгийн бүртгэлийн дүн нь бодит үнэ цэнтэйгээ ойролцоо байна. Компани нь хугацаатай хадгаламжаас жилд 8.2% (2022: 3.6%-иас 8.2%)-ийн хүүний орлого олдог.

7.1. Бэлэн мөнгөн ба банканд дахь харилцах, хадгаламжийн үнэ цэнийн бууралтын сан

	2023 мян.төг	2022 мян.төг
1 сарын 1-нээр	941	78
Тайлант жилд байгуулсан/(буцаасан) (Тод.4)	(887)	863
12 сарын 31-нээр	54	941

Компанийн дотоодын үнэлгээний систем болон жилийн эцсийн ангилал дээр үндэслэн бэлэн мөнгө ба банканд дахь дансны зээлийн чанар болон зээлийн эрсдэлийн дээд хэмжээг доорх хүснэгтэд харуулав. Дүнгүүд нь үнэ цэнийн бууралтыг хасаагүй дүнгээр илэрхийлэгдсэн болно.

	2023 Шатлал 1 мян.төг	2022 Шатлал 1 мян.төг
Дотоод үнэлгээний зэрэг		
В-ээс В+ үнэлгээтэй	1,989,706	2,518,063

Доорх хүснэгтэд нийт дансны үнэ болон холбогдох ЗҮЦХА-н сангийн өөрчлөлтийг харуулав.

	2023 Шатлал 1 мян.төг	2022 Шатлал 1 мян.төг
Дансны нийт дүн 1 сарын 1-нд	2,518,063	3,912,600
Шинээр үүссэн эсвэл худалдан авсан хөрөнгө	31,707,337	31,184,544
Үл хүлээн зөвшөөрсөн эсвэл төлөгдсөн хөрөнгө	(32,235,694)	(32,579,081)
12 сарын 31-нээрх	1,989,706	2,518,063
ЗҮЦХА-н дүн 1 сарын 1-нд	941	78
Шинээр үүссэн эсвэл худалдан авсан хөрөнгө	11,849	622
Үл хүлээн зөвшөөрсөн эсвэл төлөгдсөн хөрөнгө	(12,046)	(649)
Өгөгдлийн өөрчлөлтөөр ЗҮЦХА-д үзүүлэх нөлөө	(690)	890
12 сарын 31-нээрх	54	941

МИК ХОЛДИНГ ХК

Санхүүгийн тайлангийн тодруулгууд – 2023 оны 12 дугаар сарын 31

8. Бусад хөрөнгө

	2023 мян.төг	2022 мян.төг
Санхүүгийн хөрөнгө		
Охин компаниудаас авах авлага (Тод. 17)	208,733	35,830
Бусад авлага	2,193	–
	<u>210,926</u>	<u>35,830</u>
Санхүүгийн бус хөрөнгө		
Урьдчилж төлсөн төлбөр	–	29,091
Бусад хөрөнгө	4,034	4,043
	<u>4,034</u>	<u>33,134</u>
	<u>214,960</u>	<u>68,964</u>

9. Үндсэн хөрөнгө

	Тавилга эд хогшил мян.төг	Компьютер мян.төг	Нийт мян.төг
2023 оны 12 сарын 31-нээр			
Өртөг			
2023 оны 1-р сарын 1-нээр	26,993	65,470	92,463
Нэмэгдсэн	–	13,883	13,883
2023 оны 12-р сарын 31-нээр	<u>26,993</u>	<u>79,353</u>	<u>106,346</u>
Хуримтлагдсан элэгдэл			
2023 оны 1-р сарын 1-нээр	4,451	41,318	45,769
Тайлант жилд байгуулсан (Тод. 5)	2,700	23,487	26,187
2023 оны 12-р сарын 31-нээр	<u>7,151</u>	<u>64,805</u>	<u>71,956</u>
Дансны цэвэр үнэ	<u>19,842</u>	<u>14,548</u>	<u>34,390</u>
2022 оны 12 сарын 31-нээр			
Өртөг			
2022 оны 1-р сарын 1-нээр	20,339	38,100	58,439
Нэмэгдсэн	6,654	27,370	34,024
2022 оны 12-р сарын 31-нээр	<u>26,993</u>	<u>65,470</u>	<u>92,463</u>
Хуримтлагдсан элэгдэл			
2022 оны 1-р сарын 1-нээр	1,926	12,110	14,036
Тайлант жилд байгуулсан (Тод. 5)	2,525	29,208	31,733
2022 оны 12-р сарын 31-нээр	<u>4,451</u>	<u>41,318</u>	<u>45,769</u>
Дансны цэвэр үнэ	<u>22,542</u>	<u>24,152</u>	<u>46,694</u>

МИК ХОЛДИНГ ХК

Санхүүгийн тайлангийн тодруулгууд – 2023 оны 12 дугаар сарын 31

10. Биет бус хөрөнгө

	2023	2022
	мян.төг	мян.төг
Өртөг		
1 дүгээр сарын 1-нээр	34,514	1,559
Нэмэгдсэн	–	34,514
Данснаас хассан	–	(1,559)
12 дугаар сарын 31-нээр	<u>34,514</u>	<u>34,514</u>
Хуримтлагдсан хорогдол		
1 дүгээр сарын 1-нээр	8,903	1,559
Тайлант жилд байгуулсан (Тод. 5)	14,262	8,903
Данснаас хассан	–	(1,559)
12 дугаар сарын 31-нээр	<u>23,165</u>	<u>8,903</u>
Дансны цэвэр дүн	<u>11,349</u>	<u>25,611</u>

11. Охин компаниуд дахь хөрөнгө оруулалт

	2023	2022
	мян.төг	мян.төг
Хөрөнгийн бирж дээр бүртгэлгүй хувьцаа, өртгөөрөө	<u>73,075,105</u>	<u>73,075,105</u>

Монгол улсад бүртгэлтэй, оршин суудаг охин компаниуд болон түүний үндсэн үйл ажиллагааны талаарх дэлгэрэнгүй мэдээллийг дараах байдлаар харуулав:

Компанийн нэр	Үндсэн үйл ажиллагаа	Эзэмшиж буй өмчийн хувь	
		2023	2022
МИК ОССК ХХК	Ипотекийн зээл худалдан авах, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, гүйлгээний удирдлагын үйлчилгээ	100%	100%
МИК Рийл Эстэйт ХХК	Үл хөдлөх хөрөнгийн худалдаа, зуучлалын үйлчилгээ	100%	100%
МИК Протега Ферст ХХК	Худалдааны зуучлалын үйлчилгээ	100%	100%

МИК ОССК ХХК-ийн охин компаниудын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг дараах байдлаар харуулав:

Компанийн нэр	МИК ОССК ХХК нь эзэмшиж буй өмчийн хувь	
	2023	2022
МИК Актив Нэг ТЗК ХХК	100%	100%
МИК Актив Хоёр ТЗК ХХК	100%	100%
МИК Актив Гурав ТЗК ХХК	100%	100%
МИК Актив Дөрөв ТЗК ХХК	100%	100%
МИК Актив Тав ТЗК ХХК	100%	100%
МИК Актив Зургаа ТЗК ХХК	100%	100%
МИК Актив Долоо ТЗК ХХК	100%	100%
МИК Актив Найм ТЗК ХХК	100%	100%
МИК Актив Ёс ТЗК ХХК	100%	100%
МИК Актив Арав ТЗК ХХК	100%	100%
МИК Актив Арван Нэг ТЗК ХХК	100%	100%
МИК Актив Арван Хоёр ТЗК ХХК	100%	100%
МИК Актив Арван Гурав ТЗК ХХК	100%	100%
МИК Актив Арван Дөрөв ТЗК ХХК	100%	100%
МИК Актив Арван Тав ТЗК ХХК	100%	100%
МИК Актив Арван Зургаа ТЗК ХХК	100%	100%
МИК Актив Арван Долоо ТЗК ХХК	100%	100%
МИК Актив Арван Найм ТЗК ХХК	100%	100%

МИК ХОЛДИНГ ХК

Санхүүгийн тайлангийн тодруулгууд – 2023 оны 12 дугаар сарын 31

11. Охин компаниуд дахь хөрөнгө оруулалт (үргэлжлэл)

Компанийн нэр	МИК ОССК ХХК нь эзэмшиж буй өмчийн хувь	
	2023	2022
МИК Актив Арван Ёс ТЗК ХХК	100%	100%
МИК Актив Хорь ТЗК ХХК	100%	100%
МИК Актив Хорин нэгТЗК ХХК	100%	100%
МИК Актив Хорин Хоёр ТЗК ХХК	100%	100%
МИК Актив Хорин Гурав ТЗК ХХК	100%	100%
МИК Актив Хорин Дөрөв ТЗК ХХК	100%	100%
МИК Актив Хорин Тав ТЗК ХХК	100%	100%
МИК Актив Хорин Зургаа ТЗК ХХК	100%	100%
МИК Актив Хорин Долоо ТЗК ХХК	100%	100%
МИК Актив Хорин Найм ТЗК ХХК	100%	100%
МИК Актив Хорин Ёс ТЗК ХХК	100%	100%
МИК Актив Гуч ТЗК ХХК	100%	100%
МИК Актив Гучин Нэг ТЗК ХХК	100%	100%
МИК Актив Гучин Хоёр ТЗК ХХК	100%	100%
МИК Актив Гучин Гурав ТЗК ХХК	100%	–
МИК Актив Гучин Дөрөв ТЗК ХХК	100%	–

МИК ОССК ХХК-ийн охин компаниудын үндсэн үйл ажиллагаа нь ипотекийн зээл худалдан авах, барьцаалсан бонд гаргах явдал юм. Бүх компаниуд Монгол улсад бүртгэлтэй бөгөөд үйл ажиллагаагаа явуулдаг.

12. Бусад өр төлбөр

	2023 мян.төг	2022 мян.төг
Санхүүгийн өр төлбөр		
Охин компани дахь богино хугацаат өр төлбөр (Тод.17)	–	137,006
Бусад өр төлбөр	50,147	33,401
	<u>50,147</u>	<u>170,407</u>

13. Санхүүгийн баталгааны нөөц

	2023 мян.төг	2022 мян.төг
Санхүүгийн баталгаа	<u>798,875</u>	<u>2,442,602</u>

Тодруулга 3-т дурдсанчлан Компани нь 2021 оны 2-р сард өөрийн охин компани МИК ОССК ХХК-ийн олон улсын хөрөнгийн зах зээлд гаргасан үнэт цаасанд санхүүгийн баталгаа гаргасан. Уг үнэт цаасыг 250 сая ам.долларын нэрлэсэн үнээр гаргасан бөгөөд жилийн 8.85 хувийн хүүтэй, хүүний төлбөрийг 2021 оны 8-р сарын 8-наас 2024 оны 2-р сарын 8-ны хооронд хагас жил тутамд төлөх нөхцөлтэй.

Гэрээний дагуу Компани нь үндсэн төлбөр, хүү болон үнэт цаастай холбоотой бусад бүх төлбөрийг цаг тухайд нь төлөхийг бүрэн бөгөөд болзолгүйгээр баталгаажуулах үүрэгтэй. Энэхүү баталгаа гаргасантай холбоотойгоор Компани нь 7.3 тэрбум төгрөгийн шимтгэл хүлээн авсан ба үүнийг баталгааны хугацаанд шулуун шугамын аргаар хүлээн зөвшөөрнө.

Санхүүгийн баталгааны нөөцийг Компанийн анхлан хүлээн зөвшөөрсөн дүнгээс орлогын тайланд хүлээн зөвшөөрсөн хуримтлагдсан хорогдлыг хасаж тооцсон дүн болон эрсдэлийн сангийн хэмжээ хоёрын аль ихээр хэмжинэ. Компани нь 2023 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар тус баталгаатай холбоотойгоор 575,443 мянган төгрөгийн үнэ цэнийн хүлээгдэж буй алдагдлын сан байгуулсан (Тодруулга 4-г харна уу).

Санхүүгийн баталгааг өрийн бичгийг бүрэн төлж барагдуулах, эсхүл нотолгоог хууль ёсны дагуу хүчингүй болгох зэрэг тодорхой нөхцөл байдалд чөлөөлж болно.

2023 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар өрийн үнэт цаасны үлдэгдэл 723,922 сая төгрөг (2022: 788,155 сая төгрөг) буюу 212 сая ам.доллар (2022: 229 сая ам.доллар) байна.

МИК ХОЛДИНГ ХК

Санхүүгийн тайлангийн тодруулгууд – 2023 оны 12 дугаар сарын 31

14. Энгийн хувьцаа

Компанийн нийт дүрмийн сан нь 30,000,000 ширхэг энгийн хувьцаа (2022: 30,000,000) бөгөөд нэгж хувьцааны нэрлэсэн үнэ 1,000 төгрөг байна.

2023 оны 12 дугаар сарын 31, 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдөр дууссан онуудад хувьцааны тоо болон дүрмийн сангийн дүнгийн хөдөлгөөн дараах байдалтай байна:

	Нэг бүр нь 1,000 төгрөгийн нэрлэсэн үнэтэй энгийн хувьцааны тоо	Энгийн хувьцаа мян.төг	Нэмж төлөгдсөн капитал мян.төг
2022 оны 1-р сарын 1/12-р сарын 31 болон 2023 оны 1-р сарын 1/12 сарын 31-ний өдрөөр	<u>20,709,320</u>	<u>20,709,320</u>	<u>52,225,115</u>

2023 оны 12 дугаар сарын 31 болон 2022 оны 12 дугаар сарын 31-нээр дуусгавар болсон санхүүгийн жилд Компани нь хувьцаа эзэмшигчдэдээ ногдол ашиг зарлаагүй.

2023 оны 12 дугаар сарын 31 болон 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар Компанийн хувьцаа эзэмшигчдийн бүтэц дараах байдалтай байсан:

	2023 мян.төг	2022 мян.төг
Охин компаниуд		
МИК ОССК ХХК	19.98%	19.98%
МИК Актив Нэг ТЗК ХХК	4.31%	4.31%
МИК Актив Хоёр ТЗК ХХК	2.09%	2.09%
	<u>26.38%</u>	<u>26.38%</u>
Хувийн хэвшил		
Си Эн Би Консалтинг ХХК	12.59%	12.59%
Азиа Дайверсифайд Рийл Эстэйт Фунд Нэг	11.16%	11.16%
Худалдаа Хөгжлийн Банк ХК	10.00%	10.00%
Ти Ди Би Капитал ХХК /өмнө нь Юнайтед Банкинг Корпорэйшн/	5.95%	5.95%
Ти Ди Би Секьюритис /өмнө нь Ти Ди Би Капитал ХХК/	5.30%	5.30%
Голомт Банк ХК	4.94%	4.94%
Си И Си Групп ХХК	2.36%	2.36%
Хаан Банк ХК	1.02%	1.02%
ХасБанк ХК	1.02%	1.02%
Капитрон Банк ХХК	1.02%	1.02%
Нэкус Финанс Инвестмент ББСБ ХХК	0.57%	0.63%
Чингис Банк ХХК	0.30%	0.30%
Бусад	0.16%	0.10%
	<u>56.39%</u>	<u>56.39%</u>
Төрийн хувь		
Монгол Улсын Хөгжлийн Банк ХХК	14.88%	14.88%
Төрийн Банк ХК	2.35%	2.35%
	<u>17.23%</u>	<u>17.23%</u>
Нийт	<u>100.00%</u>	<u>100.00%</u>

Санхүү, үйл ажиллагааны бодлогын шийдвэрүүд, тэр дундаа стратегийн шийдвэрүүдийг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн (“ТУЗ”) хурлаар гаргадаг. ТУЗ-ийн гишүүдийг Хувь нийлүүлэгчдийн хурлаас томилдог. 2023, 2022 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар Компанийн нийт хувьцааны 1 хувиас дээш хувийг эзэмшдэг хувьцаа эзэмшигч бүр 9 гишүүнээс бүрдэх ТУЗ-д нэг гишүүн, түүний дотор 3 хараат бус гишүүн, Монгол Банкны нэг төлөөлөгч нэр дэвшүүлэх эрхтэй арилжааны банкууд болон төрийн өмчит банкуудын төлөөлөл оролцоно. Түүнчлэн банкны бүх хувьцаа эзэмшигчид 2023 онд Компанитай материаллаг гүйлгээ хийж, бодлого боловсруулах үйл явцад оролцсон.

15. Болзошгүй өр төлбөр ба үүрэг

Шүүхийн нэхэмжлэл

Бизнесийн онцлог шинж чанарын улмаас санхүүгийн салбарт шүүхээр асуудлыг шийдэх явдал энгийн үзэгдэл байдаг. Компани нь шүүхийн нэхэмжлэлтэй хэрхэн ажиллах талаар тогтсон журамтай. Нэгэнт мэргэжлийн зөвлөгөө авсан, гарч болох хохирлын хэмжээг зохистойгоор тооцоолсон бол Компани нь тухайн нэхэмжлэлийн Компанийн санхүүгийн байдалд үзүүлж болох сөрөг нөлөөллөөс хамгаалан дансандаа залруулах бичилт хийдэг. Тайлант жилийн эцэст Компанид ямар нэг шийдэгдээгүй, томоохон хэрэг байгаагүй.

16. Хөрөнгө ба өр төлбөрийн хугацааны шинжилгээ

Дараах хүснэгтэд Компанийн хөрөнгө, өр төлбөрийг эргэн төлөгдөх, барагдах хугацаагаар шинжилгээг харуулсан байна.

	12 сар хүртэл мян.төг	12 сараас дээш мян.төг	Нийт мян.төг
2023 оны 12-р сарын 31-ний өдрөөр			
Санхүүгийн хөрөнгө			
Бэлэн мөнгө ба банкн дахь харилцах хадгаламж	1,991,953	–	1,991,953
Бусад хөрөнгө	210,926	–	210,926
	<u>2,202,879</u>	<u>–</u>	<u>2,202,879</u>
Санхүүгийн бус хөрөнгө			
Бусад хөрөнгө	4,034	–	4,034
Үндсэн хөрөнгө	–	34,390	34,390
Биет бус хөрөнгө	–	11,349	11,349
Охин компаниуд дахь хөрөнгө оруулалт	–	73,075,105	73,075,105
	<u>4,034</u>	<u>73,120,844</u>	<u>73,124,878</u>
Нийт	<u>2,206,913</u>	<u>73,120,844</u>	<u>75,327,757</u>
Санхүүгийн өр төлбөр			
Бусад өр төлбөр	50,147	–	50,147
Санхүүгийн баталгааны гэрээний сан	798,875	–	798,875
	<u>849,022</u>	<u>–</u>	<u>849,022</u>
Санхүүгийн бус өр төлбөр			
Орлогын албан татварын өр	91,165	–	91,165
	<u>91,165</u>	<u>–</u>	<u>91,165</u>
Нийт	<u>940,187</u>	<u>–</u>	<u>940,187</u>
Цэвэр дүн	<u>1,266,726</u>	<u>73,120,844</u>	<u>74,387,570</u>

МИК ХОЛДИНГ ХК

Санхүүгийн тайлангийн тодруулгууд – 2023 оны 12 дугаар сарын 31

16. Хөрөнгө ба өр төлбөрийн хугацааны шинжилгээ (үргэлжлэл)

	12 сар хүртэл мян.төг	12 сараас дээш мян.төг	Нийт мян.төг
2022 оны 12-р сарын 31-ний өдрөөр			
Санхүүгийн хөрөнгө			
Бэлэн мөнгө ба банкн дахь данс	2,524,669	–	2,524,669
Бусад хөрөнгө	35,830	–	35,830
	<u>2,560,499</u>	<u>–</u>	<u>2,560,499</u>
Санхүүгийн бус хөрөнгө			
Бусад хөрөнгө	33,134	–	33,134
Үндсэн хөрөнгө	–	46,694	46,694
Биет бус хөрөнгө	–	25,611	25,611
Охин компаниуд дахь хөрөнгө оруулалт	–	73,075,105	73,075,105
	<u>33,134</u>	<u>73,147,410</u>	<u>73,180,544</u>
Нийт	<u>2,593,633</u>	<u>73,147,410</u>	<u>75,741,043</u>
Санхүүгийн өр төлбөр			
Бусад өр төлбөр	170,407	–	170,407
Санхүүгийн баталгааны гэрээний сан	–	2,442,602	2,442,602
	<u>170,407</u>	<u>2,442,602</u>	<u>2,613,009</u>
Санхүүгийн бус өр төлбөр			
Орлогын албан татварын өр	49,121	–	49,121
	<u>49,121</u>	<u>–</u>	<u>49,121</u>
Нийт	<u>219,528</u>	<u>2,442,602</u>	<u>2,662,130</u>
Цэвэр дүн	<u>2,374,105</u>	<u>70,704,808</u>	<u>73,078,913</u>

17. Холбоотой талын тодруулга

Компани бизнесийн асуудлаар холбоотой талуудтай хэд хэдэн ажил гүйлгээг хийсэн. Бүх хувьцаа эзэмшигчид захирлуудыг томилох эрхтэй учраас удирдлага нь тэдгээрийг холбоотой тал гэж үздэг.

2023, 2022 оны 12-р сарын 31-ний байдлаар компани нь холбогдох талуудтай дараах үлдэгдэлтэй байна:

	Банкан дахь харилцах хадгаламж		Өр төлбөр*	
	2023 мян.төг (Тод. 7)	2022 мян.төг (Тод. 7)	2023 мян.төг (Тод. 12)	2022 мян.төг (Тод. 12)
МИК ОССК ХХК	–	–	–	137,006
Худалдаа Хөгжлийн Банк ХК	1,989,706	2,518,063	–	–
Нийт	<u>1,989,706</u>	<u>2,518,063</u>	<u>–</u>	<u>137,006</u>

*МИК ОССК ХХК-ийн өглөг нь хүүгүй, эргэн төлөлтийн тогтмол хуваарьгүй.

2023 оны 12-р сарын 31-ээр дуусгавар болсон санхүүгийн жилд Компани нь холбоотой талуудад байршуулсан харилцах, хадгаламжаас 164,491 мянган төгрөг (2022: 82,816 мянган төгрөг)-ийн хүүний орлого олсон.

Охин компанийн хураамжийн орлого

Олон улсын хөрөнгийн зах зээл дээр 2021 оны 2-р сард охин компани МИК ОССК ХХК-ийн гаргасан өрийн үнэт цаасанд санхүүгийн баталгаа гаргасантай холбоотой 2,219,170 мянган төгрөг (2022: 2,659,091 мянган төгрөг)-ийн шимтгэл, хураамжийн орлого (Тодруулга 3 ба 13-ыг харна уу) болон тус охин компанид үзүүлсэн менежментийн үйлчилгээний төлбөрийн орлого 800,832 мянган төгрөг (2022: 396,200 мянган төгрөг)-ийг тус тус хүлээн зөвшөөрсөн. Компани нь охин компани МИК ОССК ХХК-аас менежментийн үйлчилгээтэй холбоотой 208,733 мянган төгрөг (2022: 35,830 мянган төгрөг)-ийн авлагатай бөгөөд түүнийг тайлант хугацааны дараа барагдуулна (Тодруулга 8-г харна уу).

Холбоотой талуудтай хийх гүйлгээний нөхцөл

Компанийн бизнесийн ердийн үйл ажиллагааны үр дүнд дээр дурдсан үлдэгдэл дүнгүүд үүссэн болно.

18. Эрсдэлийн удирдлага

18.1. Товч ойлголт

Компанийн бизнесийн үйл ажиллагаа нь дор дурдсан санхүүгийн гол бүлэг эрсдэлүүдтэй тулгарч байдаг.

- Зээлийн эрсдэл. Компанийн зээлдэгч эсвэл харилцагч байгууллага нь санхүүгийн эсвэл гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж чадаагүйгээс Компани нь санхүүгийн алдагдалд орох болон мөнгөн урсгалд нөлөөлөх эрсдэл.
- Төлбөрийн чадварын эрсдэл. Төлбөрийн чадварын эрсдэл нь Компани нь өөрийн санхүүжилт татсан төлбөрийн үүргийг цаг хугацаанд нь биелүүлэх чадвар алдагдах эрсдэл.
- Зах зээлийн эрсдэл. Зах зээлийн эрсдэл нь Хүүгийн түвшин эсвэл гадаад валютын ханшийн түвшний өөрчлөлтөөс шалтгаалан Компанийн санхүүгийн хөрөнгийн үнэ цэнд сөрөг өөрчлөлт бий болох тохиолдол юм.
- Үйл ажиллагааны эрсдэл. Үйл ажиллагааны эрсдэл нь хангалтгүй эсвэл амжилттай хэрэгжээгүй дотоод процесс, ажилтан, систем, компанийн засаглал эсвэл гадаад үйл явдлаас учирч болох алдагдлын эрсдэл юм.

Компани нь эрсдэлийн удирдлагын цогц тогтолцоогоор дамжуулан эдгээр эрсдэлийг удирдахаар зорьж байдаг ба Компанийн өсөлт, бизнесийн үйл ажиллагааны тэлэлттэй уялдан эрсдэлийн удирдлагын тогтолцоо нь хөгжин, боловсронгуй болж байна. Эрсдэлийн удирдлагын тогтолцоо нь Компанийн эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааг удирдах үндсэн зарчмуудаар хангах зорилготой.

Эрсдэлийн удирдлагын бүтэц, зохион байгуулалт

Компани нь хувьцаа эзэмшигчдээс томилсон Төлөөлөн Удирдах Зөвлөл (ТУЗ)-тэй. ТУЗ нь түүний дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хороо (ЭУХ), Санхүү аудитын хороо (САХ)-оор дамжуулан активын удирдлага, хяналт болон хариуцлагыг хэрэгжүүлэх үүрэгтэй. 2023 онд компани нь Тогтвортой хөгжлийн бодлого, стратеги, зорилтуудыг боловсруулах, гүйцэтгэлийг тасралтгүй сайжруулах, хэмжүүр, зорилт, тайлагналыг хянах зорилгоор Тогтвортой Хөгжлийн Хороо ("ГХХ") байгуулсан.

ЭУХ нь Компанийн түвшний эрсдэлийн бодлого болон хүлээн зөвшөөрөгдөх эрсдэлийн түвшин, эрсдэлийн бодлого, эрсдэлийн түвшний гүйцэтгэлийг хянах, эрсдэлийн удирдлагын хэрэгслийн хүртээмжтэй байдлыг хянах зэрэг эрсдэлтэй холбоотой хяналтыг хэрэгжүүлнэ. Мөн ЭУХ төлбөрийн чадвар болон зах зээлийн эрсдэлд хяналт тавьж, САХ нь Компанийн дотоод хяналтын системд хяналт тавих болон орон сууцны зээлийн багцын худалдан авалтыг баталж байна.

Компанийн эрсдэлийн удирдлагын бодлого нь эрсдэлийн түвшинд эрсдэлийг хянах, удирдах, эрсдэлийн хязгаарыг дагаж мөрдөхийн тулд Компанид учирч буй эрсдэлүүдийг тодорхойлох, шинжлэхээр боловсруулагдсан. Эрсдэлийн удирдлагын бодлого болон тогтолцоог зах зээлийн нөхцөл байдал, бүтээгдэхүүн, үйлчилгээнд гарч буй өөрчлөлтөд нийцүүлэн тогтмол хянаж үздэг. Компани нь өөрийн сургалт, удирдлагын стандарт болон журмуудаар дамжуулан эмх цэгцтэй, үр дүнтэй хяналтын орчныг бий болгохоор зорьж байна.

18.2. Зээлийн эрсдэл

Зээлийн эрсдэл нь Компанийн харилцагч байгууллагууд гэрээний үүргээ биелүүлээгүйн улмаас Компани алдагдалд орох эрсдэл юм. Зээлийн эрсдэлийг Компанийн Эрсдэлийн Удирдлагын Газар ("ЭУГ")-аас хянадаг. ЭУГ нь харилцагч байгууллагад учирч болзошгүй байгаль орчин, нийгэм зэрэг бүхий л төрлийн эрсдэлийг зээлийн эрсдэлийн хүрээнд удирдаж, хяналтыг хэрэгжүүлж байна.

Компани нь зээлдэгчийн зээл төлөх чадамж, барьцаа хөрөнгийн үнэлгээнд орсон өөрчлөлт, харилцагч байгууллагын зээлжих чадвар зэргийг урьдчилан таамаглах арга аргачлалыг тодорхойлсон бөгөөд үүний дагуу тогтмол давтамжтайгаар эрсдэлийг тодорхойлон, үнэлж байна. Уг эрсдэлийн үнэлгээний процесс нь тухайн эрсдэлээс үүдэн Компанид учирч болох боломжит алдагдлыг үнэлэх, урьдчилан сэргийлэх зорилготой юм.

Мөнгөн хөрөнгө

Компанийн мөнгөн хөрөнгө нь Монгол улсад үйл ажиллагаа явуулж буй арван арилжааны банканд байршуулсан харилцах, хадгаламжаас бүрдэнэ. Мөнгөн хөрөнгөөс үүсэх зээлийн эрсдэл нь тухайн банк, санхүүгийн байгууллагын дампуурах эрсдэл юм.

Компани нь мөнгөн хөрөнгийг харилцах талуудын зээлжих зэрэглэлд үндэслэн дотоод үнэлгээний зэрэглэлд ангилдаг. Компани нь харилцах талуудын зээлжих зэрэглэлийг тодорхойлохын тулд олон улсын үнэлгээний агентлагуудын зэрэглэл зэрэг олон нийтэд нээлттэй гадаад мэдээлэлд дүн шинжилгээ хийх эсвэл жишиг үнэлгээний аргыг ашигладаг бөгөөд дотоод үнэлгээг тогтоодог. Зээлжих зэрэглэлийн дотоод зэрэглэлүүд дараах байдалтай байна:

18. Эрсдэлийн удирдлага (үргэлжлэл)

18.2. Зээлийн эрсдэл

Мөнгөн хөрөнгө (үргэлжлэл)

Дотоод үнэлгээ

A- ээс AAA үнэлгээ

BB- ээс BBB+ үнэлгээ

B- ээс B+ үнэлгээ

C ээс CCC+ үнэлгээ

D үнэлгээ

Дотоод үнэлгээний тодорхойлолт

Зээл төлөх чадамж маш сайн

Зээл төлөх чадамж сайн, дундаж эрсдэлийн үнэлгээнээс дээгүүр

Зээл төлөх чадамж дунд, дундаж эрсдэлийн үнэлгээнээс доогуур

Зээл төлөх чадамж дунджаас доогуур

Зээл төлөх чадамж муу

Санхүүгийн баталгаа

2021 онд тус Компани өөрийн охин компани МИК ОССК ХХК-д санхүүгийн баталгаа гаргасан бөгөөд энэ нь Компанийг төлөөлөн төлбөр төлөх үүрэг бий болгож буй гэрээ юм. Энэхүү баталгаа нь банкна дахь харилцах, хадгаламжтай адил эрсдэлд оруулдаг тул холбогдох эрсдэлийн журам, бодлого нь ижил байна.

18.3. Хөрвөх чадварын эрсдэл

Компанийн хөрвөх чадварыг удирдах аргачлал нь хэвийн болон хэвийн бус нөхцөлд хүлээн зөвшөөрөгдөхгүй хохирол учруулахгүй мөн Компанийн нэр хүндэд хохирол учруулахгүйгээр өр төлбөрийг төлөх хангалттай тогтвортой байдлыг хангах юм. Компани хөрвөх чадварын эрсдэлийг удирдахдаа доор дурдсан аргуудыг хэрэгжүүлсэн.

Хөрвөх чадварын эрсдэлд өртөх

Компанийн хөрвөх чадварын эрсдэлийг удирдахад ашигладаг гол хэмжүүр бол цэвэр хөрвөх чадвартай хөрөнгийн эргэлтийн өр төлбөрийн харьцаа юм.

Компанийн томоохон санхүүгийн өр төлбөр нь 2021 оны 2-р сард охин компанийн олон улсын хөрөнгийн зах зээлд гаргасан өрийн үнэт цаасанд гаргасан санхүүгийн баталгаанаас бүрддэг.

Компани нь холдинг компанийн хувьд санхүүгийн үүргээ биелүүлэхийн тулд охин компаниудаас ногдол ашиг авах эсэхээс хамаардаг. Гэсэн хэдий ч охин компаниудын ногдол ашиг төлөх боломж нь орон сууцны ипотекийн зээлээр баталгаажсан бонд гаргахтай холбоотойгоор хязгаарлагдсан байдаг. Өөрөөр хэлбэл ИЗББ гаргасан охин компанийн хуримтлагдсан ашгийг компанийн дүрэм болон холбогдох Санхүүгийн зохицуулах хорооны журмын дагуу татан буулгах хүртэл хуваарилахыг хязгаарласан.

"МИК ОССК" ХХК-ийн үнэт цаасны эргэн төлөлтийн хуваарь нь худалдан авсан ипотекийн багцаас эргэн төлөлт цуглуулахаас үл хамааран тогтмол хэвээр байна. Харин "МИК ОССК" ХХК нь 90 хоногоос дээш хугацаа хэтэрсэн ипотекийн зээлийн эх үүсвэрээр худалдан авсан ипотекийн зээлийг тухайн арилжааны банкнаас солих, буцаан авах хүсэлт гаргах эрхтэй учраас төлбөрийн чадварын эрсдэл багатай гэж удирдлагаас дүгнэсэн.

18.4. Зах зээлийн эрсдэл

Зах зээлийн эрсдэл гэдэг нь зах зээлийн нөхцөл байдал, тухайлбал зээлийн хүү, гадаад валютын ханшийн өөрчлөлт нь Компанийн орлого эсвэл эзэмшиж буй санхүүгийн хөрөнгийн үнэ цэнд нөлөөлөх эрсдэл юм. Зах зээлийн эрсдэлийн удирдлагын зорилго нь эрсдэлийн өгөөжийг оновчтой болгохын зэрэгцээ зах зээлийн эрсдэлийг хүлээн зөвшөөрөгдсөн параметрийн хүрээнд удирдах, хянах явдал юм.

18.5 Үйл ажиллагааны эрсдэл

Үйл ажиллагааны эрсдэл нь компанийн бизнес зорилгод сөргөөр нөлөөлж болзошгүй үйл ажиллагааны тохиромжгүй, доголдолтой байдал болон ажилтны алдаа, залилан мэхлэлт, гадаад хүчин зүйлсээс шалтгаалан үүсэх санхүүгийн болон санхүүгийн бус алдагдал хүлээж болзошгүй эрсдэл юм. Үйл ажиллагааны эрсдэлийг хянаагүй нөхцөлд нэр хүндэд хохирол учрах, хууль эрх зүйн болон зохицуулалтын үл нийцлийн үр дагаварт хүргэх болон санхүүгийн алдагдалд хүргэж болзошгүй. Компани нь үйл ажиллагааны бүхий л эрсдэлийг арилгах боломжгүй ч хяналтын давхар тогтолцоо, харилцагч нартай шууд харилцдаг алба болон арын албаны чиг үүргүүдийн хоорондын үүрэг хариуцлагыг тусгаарлах, системд хяналттай нэвтрэх, зөвшөөрөл болон зохицуулалтыг журмуудаар олгох, ажилтнуудын боловсрол болон үнэлгээний үйл явц, дотоод аудитыг ашиглах зэргээр үйл ажиллагааны эрсдэлийг удирдаж байна.

19. Санхүүгийн хэрэгслийн бодит үнэ цэнэ

Санхүүгийн тайланд бодит үнэ цэнээр бүртгэгдээгүй санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийн тодорхойлоход ашигласан арга зүй, таамаглалыг доор тайлбарлав.

Бодит үнэ цэнэ нь дансны үнэд ойртсон санхүүгийн хэрэгслүүд

2023, 2022 оны 12-р сарын 31-ний байдлаар компанийн санхүүгийн хэрэгслүүд нь нэг жилээс бага хугацаатай богино хугацаатай байдаг. Бодит үнэ цэнийн үнэлгээнд үндэслэн санхүүгийн байдлын тайлангийн өдрийн байдлаар тэдгээр богино хугацаат санхүүгийн хөрөнгө болон санхүүгийн өр төлбөрийн тооцоолсон бодит үнэ цэнэ нь санхүүгийн байдлын тайланд тусгагдсаны дагуу дансны дүнтэй ойролцоо байна.

20. Хөрөнгийн удирдлага

Хөрөнгийг удирдахдаа Компанийн зорилго нь хувьцаа эзэмшигчдэдээ өгөөж өгөхийн тулд Компанийг тасралтгүй үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх, нэг болон хоёр дахь түвшний охин компаниудын хөрөнгөө үр дүнтэй удирдан чиглүүлэх замаар үүргээ биелүүлэх боломжийг хамгаалахад оршино. Хөрөнгийн бүтцийг хадгалах, тохируулахын тулд компани нь хоёр дахь түвшний охин компаниудаар дамжуулан шинэ хувьцаа гаргах, зээл авах, зөвшөөрөгдсөн хөрөнгө оруулалтад хөрөнгө оруулах, бонд гаргах боломжтой.

Батлан даагчийн хувьд “МИК ОССК” ХХК-ийн 2021 онд гаргасан өрийн үнэт цаастай холбоотой гэрээний дагуу ногдол ашиг хуваарилахыг хязгаарласан.

21. Тайлант хугацааны дараах үйл явдлууд

Компани олон улсын хөрөнгийн зах зээл дээр 2024 оны 1-р сард охин компани МИК ОССК ХХК-ийн гаргасан өрийн үнэт цаасанд санхүүгийн баталгаа гаргасан.

22. Монгол хэл дээрх орчуулга

Эдгээр санхүүгийн тайлангуудыг Англи хэл дээр мөн бэлтгэсэн болно. Монгол, Англи хувиудын хооронд утга, агуулгын зөрүү гарах тохиолдолд Англи хэл дээрх хувийг дагана.